

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

ЭЦЭГ ЭХЭД ЗОРИУЛСАН АЯНЫ БОГЦ



УНГАМ
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛСАД НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

Дэлхийн банк болон Швейцарийн хөгжлийн агентлаг санхүүжүүлэн хэрэгжүүлж буй энэ төсөл 10 аймаг, Улаанбаатар хотын 3 дүүрэгт хэрэгжиж байна.

Төслийн ерөнхий зорилго: Нийгмийн эгэх хариуцлагыг (НЭХ) бэхжүүлснээр орон нутгийн иргэд төрийн шийдвэр гаргах үйл явцад оролцох, чанартай үйлчилгээг хүртэх боломжоор хангагдана.

"САЙН ЗАСАГЛАЛААС САЙН СУРГУУЛЬ" ТӨСӨЛ

"Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд Говь-Алтай аймагт хэрэгжих энэхүү дэд төслийн зорилго нь иргэний оролцоотойгоор боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах, ил тод байдлыг хөхиүлэн дэмжих юм.

Төслийн удирдлагын төрийг төлөөлөн Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, төрийн бус байгууллагыг төлөөлөн "Алтай Швейцарь сан" ТББ болон бусад байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон нутгийн төслийн баг гардан хэрэгжүүлж байна.

Нийгмийн эгэх хариуцлагын талаар мэдлэг, туршлагатай үндэсний хэмжээний ТББ-ын хувиар "Бүх нийт боловсролын төлөө!" Иргэний нийгмийн үндэсний эвсэл төслийн хүрээнд зөвлөн туслах үүрэгтэйгээр хамтран оролцож байна.

ISBN 978-999785332-6

ТӨСЛИЙН ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

"Бүх нийт боловсролын төлөө!" Иргэний нийгмийн үндэсний эвсэл

Утасны дугаар: (976) 7000-8292

Цахим шуудан: coordinator@all4education.mn

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс

Утасны дугаар: (976) 7048-4065

"Алтай Швейцарь сан" төрийн бус байгууллага

Утасны дугаар: (976) 7048-4761; (976) 9948-2068

Цахим шуудан: tsetsegsdc@yahoo.com

"Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд Говь-Алтай аймагт хэрэгжсэн "Сайн сургуулиас сайн засаглал" дэд төслийн хүрээнд боловсруулан хэвлүүлэв.

Зохиосон: Б.Болорсайхан

Хянасан: Д.Тунгалаг

Гэрэл зургийг А.Мөнхбаяр, Б.Буянхишиг нарын зөвшөөрөлтэй ашиглав

Энэхүү бүтээлийн зохиогчийн болон бусад холбогдох эрх "Бүх нийт боловсролын төлөө!" Иргэний нийгмийн үндэсний эвсэлд хадгалагдана.

© Хэсэгчлэн болон бүхэлд нь ямар нэг хэлбэрээр ашиглах, хэвлэх, олшруулах тохиолдолд vice@all4education.mn хаягаар холбогдон зөвшөөрөл авна уу.

Улаанбаатар хот 2017 он

ГАРЧИГ

Богцонд юу байгаа вэ? Богцтойгоо танилцах нь	4
Эхний өдөр. Хүүхдээ ойлгох нь: Хүүхэд гэж хэн бэ?	6
2 дахь өдөр. Хүүхэд насаа эргэн санавал: Хүүхдийнхээ оронд өөрийгөө тавьж үзэх нь	8
3 дахь өдөр. Гэр бүлийн халуун яриа – Хүүхдийн ярьсан жишээн дээр ажиллах	9
4 дэх өдөр. Хүүхдээ сайн хүн болгохын тулд	12
5 дахь өдөр. Хүүхдийнхээ боловсролд хувь нэмрээ оруулах: 1000 хоног + Багштай хамтрах	16
6 дахь өдөр. Хүүхдийн орон зай: Засаглал хүртэл тэлэх нь	20
7 дахь өдөр. Хүүхэд байгаа бүх газрыг анхаар! Зураглал хийх	22
8 дахь өдөр. Хүүхдийн тань сургууль: Материаллаг, сэтгэлзүйн, засаглалын орчин сайтай юу?	23
9 дэх өдөр. Сайн дураар гар бие оролцох-Хошуу ба хуруу нэмэх	27
10 дахь өдөр. Багштай ярилцаарай. Ойлголцохын тулд ярилцаж үзэх	28
11 дэх өдөр. Та хүүхдийнхээ хувьд хэн бэ?	30
12 дахь өдөр. Бүтээлчээр хамтрах-Та, чи, бид, тэд...ер нь бүгдээр	31
13 дахь өдөр. Дүр бүтээе! Хэний?	35
14 дэх өдөр. Хамтдаа төлөвлөнө.	37
Танд өгөх урамшуулал	39



ЭЦЭГ ЭХЭД ЗОРИУЛСАН БОГЦ

Сургуульд сурах хугацаандаа хүүхэд бие даан суралцаж, амьдрах, нийгэмд байр сууриа олох, бусдад дэмжлэг үзүүлэх ур чадварыг олж авдаг. Эцэг эхийн зүгээс хүүхдээ сургуульд суралцах үед хамтдаа хөгжих, нэг нэгнээ дэмжих, эцэг эхийн хувиар хүүхдээ удирдан залахад энэхүү богцыг зориулав.

ХЭН?

Нэгдүгээр ангид орсон 6 настай хүүхдээс 18 нас хүртэлх сургуулийн суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан юм. Энэхүү гарын авлагыг ашигласан туршлагаа хуваалцан улам сайжруулах санааг хэлэх, шинээр олж авсан зүйлсээ бусад эцэг эхтэй хуваалцаж, түгээн дэлгэрүүлэх боломжтой.

ХЭЗЭЭ?

Та хичээлийн бус цагаар, гэртээ хүүхдүүдтэйгээ хамт байхдаа энэхүү богцыг ашиглана. Та 14 өдөр гэртээ байлгаж ашиглах зориулалттай. Нэг удаа бүгдийг дуусгах хэрэггүй, өдөр тутам нэг даалгаврыг чанартай сайн гүйцэтгээрэй. Та өөртөө хэрэгтэй зүйлсийг авч үлдэх нь чухал.

ХААНА?

Та өөрийнхөө гэртээ, эсвэл хүүхдийнхээ амьдарч байгаа дотуур байранд, мөн асрамжийн газарт, нэг бол тухайн хүүхдийг асарч хамгаалж байгаа өрх гэрт зэрэг хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үүрэг хүлээсэн хүн бүр

хүүхэдтэй хамт байхдаа ашиглах зорилгоор боловсруулсан билээ.

ХЭРХЭН?

Гэр бүл, ойр дотны хүмүүсээр дамжуулан хүүхдийн эсэн мэнд амьдрах, өсөж дэвжих, сайн суралцах, өөрийгөө хөгжүүлэхэд дэм болох алхамчилсан заавар байдлаар хийсэн. Бусдад тайлагнахад зориулж биш, өөртөө мэдлэг нэмж, чадварт сурч, хандлагаа өөрчлөх зорилго тавьж ашиглаарай.

ЯАГААД?

Боловсрол бол хүний эдэлвэл зохих эрхийн зэрэгцээ бусад эрхээ эдлэх суурь болдог онцлогтой. Иймээс хүүхдийнхээ боловсролд эцэг эх бага ангиас нь анхаарч, дунд, ахлах ангид мөн адил анхаарал тавих нь сурлагын чанар, төлөвшлийн ахицыг сайжруулахад сургуульд төдийгүй тухайн орон нутгийн хөгжилд хувь нэмэртэй байдаг.

ЮУНД?

Эцэг эх гар, бие оролцож, хүүхдийнхээ хөгжлийг дэмжих боломжтойг, сургуультай хамтран ажиллах арга замыг санал болгох зорилготой болно. Уламжлалт эцэг эхийн зөвлөлд гишүүн байх, хуралд оролцохоос гадна сургуулийн үйл ажиллагаанд оролцоогоо улам нэмэгдүүлэхэд тусална.





ТА ХҮҮХДИЙГ СУРАЛЦАХ, ТӨЛӨВШИХӨД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ НЬ ЯМАР АЧ ХОЛБОГДОЛТОЙ ВЭ?

Хүүхэд гэр бүлийн орчинд өсөж хөгжих, улмаар нийгэмших үйл явцыг эцэг эх, асран хамгаалагч мэдлэгтэйгээр удирдан чиглүүлэх, хүүхэдтэйгээ чөлөөтэй харилцах, хамтдаа асуудлыг шүүн тунгаах зэргээр дэмжих нь өмнөө тавьсан зорилготой, ур чадвартай хүн болгож төлөвшүүлнэ. Хүүхэд “Гэдэс цатгалан, мөр бүтэн байвал боллоо” гэдэг ойлголт хуучирсан. Сайн төлөвшсөн хүн бол эргээд нийгэмд төдийгүй бүр гэр бүлийн гишүүдээ өргөж тэтгэх, асран хамгаалах боломж ч өндөр, нийгэмд тулгардаг ядуурал, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтын эсрэг зогсох нэгэн болдог.

“ЭЦЭГ ЭХИЙН БОГЦ”-ЫГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

- Хүүхэд, гэр бүлийнхэн, ойр тойрныхонтойгоо богцоо хэзээ ашиглахаа тохирч, цаг товлоорой.
- Богцтойгоо бүтнээр нь танилцаж, өдөр бүр гүйцэтгэх даалгавраа нягтлаарай.
- Дасгалын зааврын дагуу аль болох тоглоом тоглож байгаа мэт чөлөөтэй, идэвхтэй, санаачилгатай гүйцэтгээрэй.
- Сурсан, мэдсэн зүйлээ нэг удаа биш, өөртөө зуршил болтол дахин давтаж хийгээрэй.
- Мэдэхгүй зүйл гарвал тэмдэглэж аваад, богцонд хийгээд багшид явуулаарай.

ТА ХЭН БЭ?

Эцэг эх ↓	Тийм бол →	Та заавал үүнийг ашиглаж, өөрийн болгоорой.
Үгүй бол ↓		
Асран хамгаалагч ↓	Тийм бол →	Та хүүхэдэд ээж аавын адил хандаарай.
Үгүй бол ↓		
Гэр бүлийн гишүүн ↓	Тийм бол →	Энэ хүүхэд хэрхэн хөгжиж байгааг хөндлөнгөөс ажиглаж, тусалж дэмжээрэй.
Үгүй бол ↓		
Гэр бүлийн найз ↓	Тийм бол →	Эцэг эхийн хувиар найзтайгаа хүүхэд хэрхэн өсгөх, хүмүүжүүлэх талаар санал бодол, туршлагаа хуваалцаарай.
Үгүй бол ↓		
Таньж мэддэг хүн ↓	Тийм бол →	Та ирээдүйд эцэг эх болохын хувиар өөрөө уншиж танилцаарай. Хэрэв эцэг эх, асран хамгаалагч болсон тохиолдолд танд болон өөртөө хэрэгтэй гэж тооцоорой. Мөн эцэг эх, асран хамгаалагчид дамжуулаарай.
Үгүй бол ↓		
Та уншиж танилцаад, эцэг эхэд хэлэх, эсвэл тэдэнд дамжуулаарай.		

ЭХНИЙ ӨДӨР

ХҮҮХДЭЭ ОЙЛГОХ НЬ



Та хүүхдээ төрөхөд, ээж, аав хэмээн анх удаа дуудуулахад цоо шинэ мэдрэмж төрсөн биз ээ. Цаашилбал дөнгөж хорвоод мэндэлсэн тэр хүүхэд ой хүрэх үед та ч гэсэн нэг настай ээж, аав болдог. Бид хорвоод шууд ажил амьдралын туршлагатай мэндэлдэггүй шиг, аав ээж байхыг хүртэл дэргэдээсээ, өөрөө хийж суралцах нь элбэг. Иймээс бүгдээрээ хүүхдээ таньж мэдэхээс эхэлье.

Бэлдэх зүйл: Зургийн дэвтэр, бал, харандаа, баллуур

Заавар:

1. Та цаасны голд хүүхдээ дүрслэн зурж, юу мэддэг, чаддаг, юу боддог болохыг асууж бичээрэй. Аливаа дарамтад өртөхгүй чөлөөтэй өсөх, асар их хувь заяаг олж төрсөн хүн хэмээх бодьгал гэж хүндэтгэж харилцаарай.
2. Бид хүүхдийн хөгжил, төлөвшлийг бие махбод, оюун ухаан, сэтгэл санаа, ёс суртахуун, нийгэмшил гэсэн хэсэгт хуваасан байгаа. Та хүүхдээсээ асууж:

бие махбодын хувьд: үеийнхнээсээ өндөр, намхан, тарган, туранхай, хурдан, шаламгай гэх мэтээр;

оюун ухааны хувьд: шүүн тунгаадаг, тэсвэртэй, өөрийн бодолтой, шийдвэр гаргадаг гэх мэтээр;

нийгэмшлийн хувьд: хүнтэй мэндлэх, асуултад хариулах, өөрт байгаа зүйлээ хуваалцах, бусдыг анхаарах, халамжлах гэх мэтээр;

ёс суртахууны хувьд: зөв, бурууг ялгах, шударга талд дуугарах, зүй бус үйлдлийг буруушаах;

сэтгэл санааны хувьд: итгэх, найдах, бишрэх, хүндэтгэх зэрэг үйлдлийг цаасан дээр бичиж эсвэл дүрслээрэй.

Бие махбод

Нийгэмшил

Оюун ухаан

Ёс суртахуун

Сэтгэл санаа



3. Хамтдаа насанд хүрсэн том хүнээс хүүхэд юугаараа ялгаатайг ярилцаарай. Ямар үед аз жаргалтай байдаг, ямар үед хэцүү байдаг, юу хүнд санагддаг, “Ээж, аавыгаа ямар байгаасай” гэж хүсдэг талаар асууж харилцан ярилцаарай.
4. Ямар үед бусдын туслалцаа, дэмжлэг хэрэгтэй болдог, яагаад гэдгийг ярилцаарай. Бага насны хүүхэдтэй бол хамт зургаар илэрхийлж болно.
5. “Хүүхэд төрсөн цагаасаа том болох буюу багадаа 18 нас хүртлээ насанд хүрэгчдээр халамжлуулах, хамгаалуулах, хөгжихүйц таатай орчинд байж, эсэн мэнд, өвчин зовиургүй, айх айдасгүй, гачигдах зовлонгүй амьдардаг юм” гэдгийг тайлбарлаж өгөөрэй.

Хүүхэд бол **ХҮН**. Хүүхэд өөрийн гэсэн:

- Мэдлэг
- Ур чадвар
- Туршлага
- Хандлага
- Үзэл бодолтой тул та хүндэтгэн харилцана уу.

Гэхдээ нөгөө талаас хүүхэд нас бол бие махбод, сэтгэл санааны хувьд бүрэн гүйцэд хөгжөөгүй, оюун ухаан, нийгэмшил, ёс суртахууны хувьд гүйцэд төлөвшөөгүйн улмаас эмзэг үе, зүй бус хандлага, мөлжлөг, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртөх илүү их

магадлалтай нас. Тиймээс 18 нас хүртлээ том хүнээс бүрэн хамааралтай байдаг юм шүү. Гэр бүлд эцэг эх, сургууль, түүний дотуур байранд багш, боловсролын ажилтнууд, олон нийтийн газар иргэд хүүхдийг халамжлах, хамгаалах үүрэг хүлээдэг. Сонгуульд санал өгөх, дунд сургууль төгсөх, ажил хөдөлмөр эрхлэх, гэрлэх, шүүхэд гэрчээр дуудах, цэрэгт татах нас хуулиар 18 гэж тогтоосон нь учиртай.

Та эцэг, эхийн хувьд хүүхдийнхээ төлөө юу хийж чадах вэ?

(Дээрх 2 санааг бодолцоно уу)

- Халамжлах:

.....

- Хамгаалах:

.....

- Бие махбод, оюун ухаан, сэтгэл санаа, нийгмийн хөгжлийг хангах:

.....



2 ДАХЬ ӨДӨР ХҮҮХЭД НАСАА ЭРГЭН САНАВАЛ...



Та өөрийнхөө хүүхэд насыг эргэн санах замаар хүүхдэдээ ямар дурсамж, хүүхэд нас үлдээмээр байгаагаа эргэцүүлж бодно. Цаашилбал танай гэр бүл, ойр дотныхонд хүүхдийн амьдралд нөлөөлөх ямар сайн сайхан зүйл, ямар нөхцөл байдал байгааг хамтдаа ярилцана.

Миний...

Хайрладаг

Хийж чаддаг

Итгэж биширдэг

Боддог

зүйлс бол....

Заавар:


1. Өмнөх өдрийн сэдвээ эргэн санах, хүүхдийнхээ оронд өөрийгөө тавьж үзэх, мөн хүүхдэдээ хүсэж байгаа ирээдүйг харахын тулд дараах зургийн дагуу “Таны ... зүйлс”-ийг дараах дөрвөн шинжээр нэрлээрэй.
2. Та дээрх дөрвөн шинжтэй холбоотой хүүхэд насны гэгээн сайхан дурсамжаасаа хүүхдэдээ ярьж өгөөрэй.

3. Хэнээсээ юуг авсан, дууриасан, үлгэрлэсэн, тэр хүн ямар хүн байсан талаар тайлбарлаарай. “Өвөө нь, авгын тал нь өндөр байсан учраас би өндөр нуруутай”, “Нагацын тал чинь энэ сум, орон нутгийн чухал албыг хашиж явсан”, “Манай удмынхан нутаг усандаа “тусч”, “цагаан мөртэй” гэж алдаршсан” гэх мэт.
4. Та хүүхдээсээ “Аз жаргалтай мөч”-ийг нь асуугаарай. Яагаад гэж лавлахдаа дээрх дөрвөн шинжийн алинтай холбоотойг давхар асуугаарай.
5. Та өөрийнхөө таалагддаггүй зүйлсийг дотроо эргэцүүлээрэй. Хэзээ, хаана, юунаас шалтгаалан ийнхүү бодох болсноо санаарай. Таны хүүхдэд ийм дурсамж үлдвэл ямар байх талаар төсөөлж, боломжтой тохиолдолд хуваалцаарай. Хэрэв хэцүү санагдвал хүүхдэдээ ийм дурсамж үлдээхгүйн тулд юу хийх талаар тунгаагаарай.
6. Хүүхэд тань байнга аз жаргалтай байхын тулд ангийн хүүхэд, үе тэнгийнхэн чухал нөлөөтэйг давхар санаарай. Тэдний зүгээс хүртэл хүүхдэд тань муухай дурсамж, муу үйлдэл хийхгүйн тулд өөрийнхөө төдийгүй бусдын хүүхдэд ч анхаарах ёстой гэдгийг санаарай.

ӨӨРТӨӨ ӨГӨХ АМЛАЛТ:

БИ эцэг эхийн хувьд дараах амлалтыг өөртөө өгч байна:

- 1.....
- 2.....
- 3.....
- 4.....
- 5.....



3 ДАХЬ ӨДӨР

ГЭР БҮЛИЙН ХАЛУУН ЯРИА



Гэр бүлээрээ хамтдаа дараах дөрвөн түүхийг уншиж, хоорондоо хэлэлцэж, ярилцаарай.


№	Тохиолдол
1	<p>СУМЫН СУРГУУЛИЙН СУРАГЧ ДОЛГИОНЫ ТҮҮХ</p> <p>Би малчин айлын хүүхэд. Тиймээс дотуур байранд 6 настайгаасаа амьдарч байна. Би бага байхдаа гэрээ санаад орондоо уйлдаг байсан. Одоо том агаа болсон. Хааяа л гэртээ харих юмсан, ээж аавтайгаа ярьж суух юм сан гэж боддог л юм.</p> <p>Манай байр гадна, дотногүй хуучирсан, дээвэр нь бүтэн биш, хаалга, хана, цонх, бариул, шат, шал бүгд будаг нь халцарсан, хагарсан, түгжээгүй. Хүүхдүүдийн өрөөнд хичээлээ давтах ширээ, сандал хүрэлцээгүй, байгаа нь хуучин, эвдэрхий. Би заримдаа даалгавраа хийж чадахгүй асуух гэхээр багшаас айдаг.</p> <p>Манай найз тэргэнцэртэй хүүхэд, сургуульд явахаар ирээд налуу шатгүй, ариун цэврийн өрөөг ашиглаж чадахгүй тул сургуулиас гарсан.</p> <p>Өрөөнд асдаг гэрэл ховор, хөвгүүд өөр өрөөний гэрэл хулгайлдаг. Унтраалга, цахилгааны залгуур эвдэрч хагарсан, гэрэл, цахилгааны утас ил гарсан заримдаа тогонд цохиулдаг.</p> <p>Халаалт муутай болохоор хүйтэн, маш их чийгтэй учраас таазны будаг, шавар хүүхдийн ор, ширээн дээр байнга унадаг. Дотроо шинээр угаалтуур, бие засах өрөө байгуулсан ч ашигладаггүй, бохир ус нь дүүрсэн гээд оруулдаггүй. Бохирыг нь соруулах машин суманд байхгүй, аймгаас ирэх боломжгүй, хол учир зардал их гарна гэж захирал хэлсэн. Байрны гадна гэрэлтүүлэг огт байхгүй тул би зарим шөнө гарч бие засч чаддаггүй, айдаг.</p>

2 ХУРДАН МОРЬ УНААЧ БУЮУ ХҮЛЭГЧ БАТБАЯРЫН ТҮҮХ

Манай гэр Төв аймагт байдаг. Гэхдээ би ихэнхдээ Өлзийт хороололд морь уядаг ахындаа байдаг. Тэр ах баян болохоороо захиралд мөнгө өгөөд намайг хичээлээс чөлөөлүүлдэг гэсэн. Ямар ч гэсэн би анги дэвшээд байгаа, гэхдээ сурсан юмаар маруухан, уг нь нэг мэргэжилтэй болоод ажил хийгээд цалин авдаг хүн болбол гоё. Би хичээлдээ гайгүй хэрэв багш нөхөөд заавал сурна л гэж боддог, даанч сургууль маань 3 ээлжтэй болохоор анги танхим олддоггүй гэсэн. Зун уралдахад ч асуудалгүй, сайхан, өвөл, хавар л хэцүү даараад, уначих вий гэж айдаг. Нэг удаа унаад гараа хугалаад өнгөрсөн. Уяач ах аймаар загнаад, элдвээр хэлсэн. Ээж рентген зураг авахуулах мөнгө гэсэн чинь ээжийг бас загнасан гэсэн. Танай урагшгүй хүүхдээс болоод байгаа алдчихлаа, юун мөнгө төгрөг гээд. Ашгүй хүүхдийн байгууллагын нэг эгч ирж уулзаад, эмнэлэгт үнэгүй зураг авахуулж өгсөн. Хааяа морь малладаг ах нарт зодуулахаараа гэрээ санадаг. Бид нарыг аль болох хөнгөн байлгах гээд хоол сойдог болохоор хааяа өлсдөг. Гэдэс гартлаа нэг идэхсэн гээд л боддог. Гэхдээ яахав дээ, ээждээ хэдэн төгрөг олж өгч байгаадаа урамшаад, хатуу хөтүүг тэсээд гарахыг боддог. Заримдаа өөрийгөө дүү нараа тэжээгээд том хүн болсон юм шиг сэтгэдэг. Том юм ярьсан пээдийсэн хүүхэд вэ гэдэг л юм зарим хүн.



3 ЗАХ ДЭЭР АЖИЛЛАДАГ ТУУЛЫН ТҮҮХ



Намайг Туул гэдэг. Би сургуульд явж байсан л даа. Том болохоороо ангийнхан шоолоод байхаар нь сургуулиасаа гарчихсан. Албан бус боловсролын төвд явж байгаад том эрэгтэй хүүхдүүд оролдоод байхаар нь явахаа больчихсон. Бага байхад амар байж дээ гэж одоо боддог, ээжтэйгээ ихэнхдээ хамт явдаг байсан. Жаахан том болохоор эрэгтэй хүмүүс хоргоогоод, татаж чангаагаад их хэцүү, өдөр ч, шөнө ч байнга айдастай явдаг. Өнгөрсөн өвөл ханиад хүрээд эм уулгүй явсаар байгаад хүндрээд уушигны хатгалгаа болсон, одоо байнга ханиалгаад байгаа. Эмнэлэгт үзүүлэхээсээ ичээд байдаг. Тэгээд ч бичиг баримтгүй болохоор намайг үзэхгүй биз. Өдөрт түлэх түлээ, хоолныхоо мөнгийг олчихвол бид 2 бөөн баяр болдог. Хувцас хунарыг бол сүмийнхэн тусламжаар өгдөг. Дүү нар гэртээ хоцорсон болохоор санаа их зовдог, бага дүүгээ нэг удаа зууханд түлсэн болохоор байнга санаа зовдог, харах хүнгүй орхивол. Ээж намайг маяглаж байж, эцэггүй хүүхэд гаргав аа гээд загнадаг. Би ч тэр талаар сайн мэдэхгүй л дээ, ичээд л өнгөрдөг.

4 СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ЗУЛААГИЙН ТҮҮХ

Би Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тусгай 29-р сургуульд сурдаг. Аав намайг өдөр бүр сургуульд хүргэж өгөх гээд малаа зарж, машин аваад халтууранд явдаг болсон.

Уг нь үеийнхээ хүүхдүүдтэй сургуульд явах их гоё, даанч бид нар багшийнхаа заасныг сайн ойлгодоггүй, зарим багш нар хичээлээ заахгүй, утсаараа фейсбүүкдээд суугаад байдаг. Саяхан манай сургууль дээр бөөн юм болсон. Төгсөх ангийн хэдэн ах нар тэмцэл хийгээд, дохионы хэлээр хичээл заа гэж шаардлага тавьсан гэсэн. Бас зурагтаар манай сургуулийг төгссөн ах, эгч нар гараад бид нар сургууль төгсөөд дээд сургуульд орж чадаагүй, ажил ч хийж чадахгүй байна гэсэн чинь надад хачин санагдсан. Би тэгээд яаж амьдарнаа, том болохоороо гээд л.

Багш нарт ч гэсэн хэцүү гэсэн, бидэнд яаж заах вэ гэдэг бодлого, гарын авлага, ном сурах бичиг байхгүй болохоор. Багш нарын цалин бас бага байдаг, орон сууцны зээлтэй, ажлаа алдвал яанаа гэж ярьж байхыг нь би сонссон. Өрөвдсөн багш нараа.

Бид нар өнгөрсөн жилийн сүүлээр хүүхдээ сонсох ажиллагаанд оролцоод өөрсдийн санал бодлоо зөндөө хэлсэн. Биелсэн эсэхийг мэдэхгүй байна. Бид нарын хэлснийг ойлгоогүй байж магадгүй, нийгмийн ажилтан дохионы хэлгүй юм чинь. Бид нар бас захиралтай, сургалтын менежер эгчтэй харилцаж бараг чаддаггүй ш дээ, тэд нар бас дохионы хэлгүй.



Тохиолдол бүрийг дүгнэж ярилцахдаа дараах асуултыг асууж, хариулах байдлаар хүүхдийнхээ насанд тохируулан санаа бодлоо хуваалцаарай.

1. Энэ хүүхэд аз жаргалтай байсан уу? Яагаад?
2. Том болоод ямар зүйлийг дурсах вэ? Ирээдүйн амьдралд нь ямар хор уршиг гарах вэ?
3. Миний хүүхэд оронд нь байсан бол ямар санагдах вэ? Яагаад?
4. Хүүхдийг ийм нөхцөл байдалд оруулахгүйн тулд чи юу хийх вэ? Бүгдээрээ юу хийх вэ?

Хүүхэд бүр харилцан адилгүй ч бусдыг ойлгож, хамтдаа суралцах, хөгжих хэрэгтэй. Тэгвэл том болсон хойноо бүгдээрээ нэг нэгнээ дэмжиж, хамтдаа сайхан амьдарна гэдгийг учирлаж, тайлбарлаж өгөөрэй.

Таны энэ өдрийн сэтгэгдэл:

.....

4 ДЭХ ӨДӨР

ХҮҮХДЭЭ САЙН БОЛГОХЫН ТУЛД...



Та өөрийгөө хүүхдээ сайн хүн болгож чадах эсэхээ мэдэхгүй, эсвэл эргэлзэж байвал дараах сонжоог¹ бөглөөрэй.

Хүснэгтийн эгнээнд байгаа өөрт таарах тоог дугуйлахыг хүснэ. Нийтэд ил болгохгүй тул өөртөө үнэнч шударгаар бөглөх хэрэгтэй.

Тоог сонгодоо:

- 1 Таны хандлага, арга зүй эерэг хүмүүжлийн багананд байгаа санаатай яг таарч байна.
 - 2 Таны хандлага, арга зүй эерэг хүмүүжлийн багананд байгаа санаатай бараг нийцэж байгаа ч зарим нэг эргэлзээтэй зүйл байна.
 - 3 Та итгэлтэй бус байна. 2 баганы хоёуланд нь байгаа санаатай санал нийлээд байна.
 - 4 Таны хандлага, арга зүй шийтгэлийн багананд байгаа санаатай бараг нийцэж байгаа ч, зарим нэг эргэлзээтэй зүйл байна.
 - 5 Таны хандлага, арга зүй шийтгэлийн багананд байгаа санаатай яг таарч байна.
- Бүх эгнээний оноог дугуйлж гүйцээсний дараа дугуйлсан оноонуудаа нэмж, нэг дүн гаргана.

1 Та өөрийгөө сонжоорой: Эерэг хүмүүжил (www.proprofs.com)

Эерэг хүмүүжил			Шийтгэл		
Урам зориг өгдөг. Хэзээ ч хүчирхийлэл хэрэглэдэггүй, хүүхдүүдийн өөртөө төлөвшүүлэхийг эрмэлзэх үнэт зүйлс, зан үйлийг өөрөө үлгэрлэн харуулж байдаг. Хүүхдүүдэд хийсэн сонголтынх нь үр дагавар ямар байх, ямар үйлдэл сайшаагдах, ямар нь зэмлэгдэхийг тодорхой ойлгуулж өгдөг.			Шийтгэдэг. Хүүхдийг ямар нэгэн урьдчилан тодорхойлсон байдлаар сэтгэх буюу биеэ авч явахыг шаардаж, зорилгодоо хүрэхийн тулд айлгаж, ичээдэг. Зодох, хэл амаар доромжлох, нэр хүндийг нь гутаах зэрэг шийтгэл хэрэглэдэг.		
А	1	2	3	4	5
Хүүхдийг өөртөө итгэлтэй, хүчирхэг болгохыг зорьдог. Хүүхдэд чөлөөтэй сэтгэх, эргэцүүлэн бодоход ээлтэй орчин бүрдүүлж, бодож сэтгэх чадварыг нь хөгжүүлж, зөв шийдвэр гаргах, хийсэн сонголтынхоо хариуцлагыг хүлээж сурахад нь тусалдаг.			Хүүхдийг дуулгавартай болгох зорилготой. Хүүхдийг бие даан сэтгэн бодохоос илүүтэй хүний үгээр явж, үгэнд орж сурах орчинг гэртээ бүрдүүлдэг.		
Б	1	2	3	4	5
Хүүхэд төвтэй. Бүх асуудлыг хүүхдийн харах өнцгөөс авч үзэж, хүүхдэд алдаанаасаа суралцахад нь туслах үүднээс бүх хариу үйлдэл, авах арга хэмжээгээ сонгодог.			Эцэг, эх төвтэй. Бүхий л нөхцөл байдалд таны хүсэл, бодол давамгайлж, таны санаа ямагт зөв гэж үздэг.		
В	1	2	3	4	5
Ардчилсан. Суралцахад хөгжиж, төлөвшихөд тус болохуйц янз бүрийн үзэл санаа, түүнчлэн алдаанд нээлттэй, хүлээцтэй ханддаг. Хэн хэнд ч ашигтай байх хэрэгжүүлж болохуйц дүрэм тогтоохыг зорьдог.			Захиргаадсан. Хүүхдүүдэд юу хийхийг нь зааж, тушааж өгдөг, тэд өөр үйлдэл сонговол тэднийг шийтгэдэг.		

Г	1	2	3	4	5
Хувь хүний онцлогийг хүндэтгэж үнэлдэг. Хүн бүр өөрийн гэсэн үзэл бодол, эрхэмлэдэг зүйлс, зорилготой гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Хувь хүмүүсийн эдгээр ялгааг та эерэгээр хардаг.			Тогтсон хэв маягт нийцүүлэхийг хүсдэг. Өөртэйгээ ижил төстэй зан үйлтэй, адил бодолтой хүүхдүүдийг урамшуулж, харин ялгаатай хүүхдээ шийтгэдэг.		
Д	1	2	3	4	5
Удаан хугацааны хөгжил. Та хүүхдийн олон талт хөгжлийг урт удаан хугацааны турш дэмжихийг зорьдог.			Богино хугацаанд үгэнд ордог байх. Таны арга барил хүүхдийг тодорхой нөхцөлд дуулгавартай байлгахад чиглэсэн. Хүүхдийн ирээдүйн, хэтийн хөгжилд нэг их ач холбогдол өгдөггүй.		

ХАРИУ:

5 – 10 оноо: Та болж өгвөл хүүхдэдээ ширүүн үг хэлэхгүй, байнга хайрлаж, анхаарч, улам цаг гаргаарай. Зөв хүмүүжүүлдэг хүн ажээ.

11 – 15 оноо: Заримдаа та өөрийнхөө үйлдлийг эргэцүүлэх буюу ядарсан, ачаалал ихтэй өдөр өнгөрүүлсэн бол тайвширч, аль болох хүүхдэдээ бухимдлаа гаргахгүй байвал хүүхдээ хүмүүжүүлэх зөв аргыг сонгож байна гэж бодоорой.

15 – 20 оноо: Та хурдан өөрийн хүссэндээ хүрч, хүүхдээ заримдаа хайрлаж, заримдаа хал нь гаднаа харилцдаг байна. Хүүхэд танд эргэлзэж, аливаа зүйлийг шийдэхдээ тээнэгэлзэх, хариуцлага хүлээж чадахгүй байх магадлалтай. Аль болох эерэгээр хүүхдээ хүмүүжүүлээрэй.

21-ээс дээш оноо: Шийтгэлээр хүмүүжүүлсэн хүүхдийн хувьд өөрийгөө чөлөөтэй илэрхийлдэггүй, дотогшоо, худалч, ичимхий, аймхай хүүхэд болох эрсдэлтэй.

Та ямар ч тохиолдолд дараах өгүүлбэрийг хэзээ ч битгий хэрэглээрэй.

Дэлбэрсэн, ууртай өгүүлбэр: Чи ч том асуудалд орлоо доо!	Шүүмжилсэн өгүүлбэрүүд: Чиний чадах юм чинь энэ л дээ!
Хориглосон өгүүлбэр: Битгий гүй!	Сүрдүүлсэн өгүүлбэр: Ярихаа болихгүй бол чамайг захирал дээр дагуулж орно шүү!
Шууд захиран тушаах: Суу, чимээгүй бай!	Доош нь хийсэн өгүүлбэр: Чи ер нь хэзээ бичиж сурах хүн бэ?

Шийтгэн хүмүүжүүлэх аргын талаар эцэг эхийн тогтсон ойлголт, хандлага, арга барил, үйл явцыг нэг өдөр шийдээд өөрчлөгдөхгүй. Учир нь энэ өөрчлөлтийн үйл явц зөвхөн хэлбэрийн тухай асуудал биш, харин бидний дотор болон нийгэмд гүн нэвчсэн захиран тушаах, хүмүүсийг ялган зиндаачлах, тухайлбал насаар ялгаварлан, хүүхдийг хүн гэж үзэхгүй байх сэтгэлгээг үндсээр нь өөрчлөх, амьдралын бүхий л хүрээнд эрх мэдлийг тэгш бус хуваарилах, ёс зүйгүй хэрэглэх байдлыг халахыг шаардаж байгаа юм. Гэхдээ энэ өөрчлөлтийг бид өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаандаа нэвтрүүлээд явах боломжтой.

Гэр дотроо эерэг хүмүүжлийн арга хэрэгжүүлэх хэм хэмжээгээ тохиролцвол хэн хэндээ амар байдаг шүү. Жишээлбэл, хэзээ ямар тохиолдолд ямар арга хэмжээ авахаа шууд шаталсан байдлаар тохирч болно.



ХҮМҮҮЖЛИЙН ЭЭРЭГ АРГА

Бид хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөггүй. Хүүхдийг хэзээ ч айлгаж, сүрдүүлж, ичээдэггүй.

Хүүхдүүдийг зодохгүй бол тэд хүмүүжилгүй болно, тэд ямар сонголт хийхээ мэдэхгүй, тэднийг ямагт хянаж байх хэрэгтэй гэж зарим хүмүүс боддог. Эерэг сахилга бат/хүмүүжлийг төлөвшүүлнэ гэдэг нь хүүхдийг хийсэн үйлдлийнх нь үр дагавраас мултална гэсэн үг биш. Эерэг хүмүүжлийн үр дагавар нь үйлдэлдээ тохирсон шударга, тууштай байх бөгөөд зорилго нь хүүхдийг доромжлоход бус, биеэ авч явах байдлыг нь засаж залруулахад чиглэсэн байна гэсэн үг. Хүүхдүүдийг шийтгэхэд биш гаргасан алдаанаасаа суралцах боломж олгоход чиглэдэг. Хүүхдийг зодох, загнах нь илүү амархан, тэр дор богино хугацаанд үр дүнгээ өгдөг: хүүхэд таны үгэнд орно, хийж байсан үйлдлээ зогсооно. Гэхдээ... таныг хараагүй үед нөгөө үйлдлээ хийж магадгүй, танаас юм нууж, магадгүй худлаа хэлж сурна. Эерэг сахилга батыг төлөвшүүлэх нь илүү хэцүү, илүү их хичээл зүтгэл шаардана, гэхдээ үр дүн нь тогтвортой бөгөөд хүүхдийн амьдралд чанарын ялгаатай.



Эерэг сахилга батыг төлөвшүүлэхэд туслахын тулд бид 4 түвшний арга хэмжээ ашигладаг:	
Эргэцүүлэл	<ul style="list-style-type: none">• Өдөр тутмын жижиг сажиг асуудал гарахад• Хүүхдүүдэд хийсэн зүйлийнхээ тухай эргэцүүлэн бодоход туслах
Торгууль	<ul style="list-style-type: none">• Давтагдаад буй асуудалд• Хүүхдүүдэд үйлдлийнхээ үр дагаврыг ойлгоход нь туслах
Залруулга	<ul style="list-style-type: none">• Хохирол гэмтэл учруулсан үйлдэлд• Хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээж сурахад нь туслах
Эцсийн арга хэмжээ	<ul style="list-style-type: none">• Ноцтой зөрчил гарахад• Хүүхдүүдэд зан үйлээ засахад шаардлагатай туслалцаа авахад туслах

1. Эргэцүүлэл

Өдөр тутмын жижиг асуудлууд гарахад хүүхдэд хийсэн буруу зүйлийнхээ талаар бодож, эргэцүүлэхийг санал болгоно. Хийсэн зүйл нь яагаад буруу байсныг ойлгох юм бол, мөн хийсэн үйлдлийнх нь талаар эргэцүүлж бодох боломж олговол хүүхдүүд алдаанаасаа суралцдаг.

Энэ ангилалд дараах сахилга бат/хүмүүжлийн арга хэмжээнүүд багтана:

- Аман анхааруулга.** Хүүхэдтэйгээ тайван ярилцаж, хийсэн үйлдэл нь яагаад буруу байсныг нь тайлбарлаж өгнө.
- "Эргэцүүлэх цаг"** Хүүхдийг нэг бол өрөөнөөс гаргаад эсвэл дуу чимээгүй газар 10 минут сууж юу хийсэн тухайгаа бодох хугацаа өгнө. Хугацаа дуусмагц хүүхэд өөрөө танд үйлдэл нь яагаад буруу байсан, цаашид тийм үйлдэл хэрхэн давтан хийхгүй байх тухай хэлнэ. Энэ аргыг хэрэглэхдээ эцэг эх хүүхдийг ямар нэгэн байдлаар гутаан доромжлохгүй, гэхдээ тууштай байх хэрэгтэй.
- Захидал бичүүлэх.** Тухайн үйлдлийг яагаад хийсэн, тэр нь яагаад буруу байсан, ийм алдааг дахин гаргахгүй байхын тулд яах вэ гэдэг талаар хүүхдээрээ өөртөө хандсан захидал бичүүлэх. Зохистой бол захидалдаа уучлалт гуйлгах.
- Амаар уучлалт гуйлгах.** Хүүхдээр бурууг нь хүлээлгэж, гомдоосон хүнээс нь уучлалт гуйлгана.
- Зөрчлийн хуудас.** Хуудсан дээр хийсэн буруу үйлдлийг нь хүүхдээрээ бичүүлнэ. Бичсэн зүйлийг гэр бүлийн гишүүдийн өмнө уншиж, бүх хүний саналыг үндэслэлтэй нь сонсож ямар арга хэмжээ авахаа шийдвэрлэнэ.
- Сахилгын хайрцаг.** Буруу үйлдэл хийсэн хүүхдийн нэрийг цаасан дээр бичээд гэрт байдаг сахилгын хайрцганд гэр



бүлийн хэн ч байсан хийж болно. Долоо хоног бүрийн эцэст хайрцгийг шалгана. Хэрэв нэг хүүхдийн нэртэй хуудас нэгээс илүү олон байх юм бол тэр хүүхдэд торгууль ногдуулна.

2. Торгууль

Эргэн тойрондоо гэм хортой үйлдлийг давтан үйлдээд байгаа тохиолдолд хүүхдүүдэд үйлдэл нь үр дагавартай байдгийг мэдрүүлэхийн тулд торгууль ногдуулах хэрэгтэй байж магадгүй. Гэхдээ торгууль ногдуулаад зогсохгүй үр дагаврын тухай эргэцүүлэн бодоход нь хүүхдэд туслах хэрэгтэй.

Энэ ангилалд багтах арга хэмжээнүүд:

- а. Давуу эрхийг нь хязгаарлах.** Хүүхдийн хийх дуртай ямар нэгэн зүйлийг хориглох, тухайлбал телевиз үзэх, компьютер дээр суух эрхийг 7 хоногоор хасах. Гэхдээ хүүхдүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд хортой торгууль ногдуулж болохгүй.
- б. Гэр, орчноо сайжруулах хөнгөн ажил хийлгэх.** Гэр, хашаа, хороогоо цэвэрлэх, багавтар талбайн шал угаах, ус авах, түлээ хагалах, нүүрс шуудайлах гэх мэт. Хийх ажил хийсэн үйлдэлтэй нь холбоотой байх хэрэгтэй. Мөн хүүхдэд маш их ичмээр, доромжлуулж байгаа гэж санагдахаар ажил байж болохгүй.
- в. Саатуулах.** Тусгайлан тохирсон нэг газар гэр бүлийн гишүүд рүү харахгүйгээр сууж, хийсэн буруу үйлдлийнхээ тухай эргэцүүлнэ.
- г. Сахилгын гэрээ байгуулах.** Хүүхдийн буруу үйлдлийг тайлбарласан, энэ алдаагаа засахын тулд хүүхдийн зүгээс авах алхмуудыг нь тоочсон нэг нүүр гэрээг хүүхэд, эцэг эхтэй байгуулна.

д. Хүүхэдтэй сахилгын яриа хийх. Хүүхэдтэй уулзаж, зан үйлийнх нь талаар ярилцан, биеэ авч явах байдлыг нь засаж залруулах төлөвлөгөө хамтдаа гаргах.

ж. Олон нийтийн үйлчилгээ. Хүүхдээр нийгэмд ямар нэгэн тустай хөнгөн хэлбэрийн ажил хийлгэх. Хүүхдээр ямар нэгэн олон нийтийн үйлчилгээний ажил хийлгэхдээ ажлын зорилгыг сайтар тайлбарлаж өгөх хэрэгтэй.

3. Залруулга

Гуравдагч талд хохирол учруулсан бол хүүхэд нийтийн өмнө залруулга хийх ёстой. Энэ нь бусдын өмнө буруугаа хүлээж, хариуцлага хүлээнэ гэсэн үг.

Энэ ангилалд багтах арга хэмжээнүүд:

- а. Нийтийн өмнө уучлалт гуйх.** Хүүхэд нийт гэр бүл, хамаатан садны өмнө буюу тухайн асуудалд холбогдсон хэсэг бүлэг хүмүүсийн өмнө буруугаа хүлээж уучлалт гуйна.
- б. Орлуулах эсвэл засварлах.** Хэрэв хүүхэд санаандгүй эд зүйлс эвдэж хэмхэлсэн бол тэдгээрийг орлуулах эсвэл засварлахад хувь нэмэр оруулна. Жишээ нь хашаа засах эсвэл шинээр барих, мод хагалах, хана будах зэрэг ажилд оролцоно.

Хүүхэд бол хүүхэд, тэд гэнэн томоогүй насан дээрээ байгаа. Тэд санаатай, санамсаргүй буруу үйлдэл хийнэ. Та хүүхдээ хүмүүжүүлэхдээ хэрэглэдэг өөрийн шилдэг арга байвал хуваалцана уу:

.....
.....

5 ДАХЬ ӨДӨР ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛД ТАНЫ ХУВЬ НЭМЭР



Таны ХҮҮХЭД хэрхэн том болж байгааг харуулахын тулд цөөн сонирхолтой баримт дурдъя. Үүнд:

- Хүүхэд эхийн хэвлийгээс төрсөн эхний 1000 хоног амин чухал. Уураг тархи ид хөгждөг үе.
 - Эхээс мэндлэхдээ 100 сая орчим тархины эстэй мэндэлдэг. Дахиж төлжиж бий болохгүй, харин хөгшрөх тусам улам багасч буурдаг.
 - Амьдралын эхний 1000 хоногт үлдсэн амьдралдаа ямар хүн болох мэдээлэл, дадал хэвшлийн 80 хувийг олж авдаг.
 - Эхний 10 жилд насанд хүрсэн хүнээс 2 дахин илүү хурдан өсөж томордог.
 - Секунд тутам 700–1000 эсийн холбоос (шинэ мэдлэг) үүсдэг.
 - 3 настай хүүхдийн уураг тархи насанд хүрсэн хүнийхээс 2 дахин илүү идэвхтэй байдаг.
 - 3 настай хүүхэд хоол тэжээлээр олсон энергийнхээ 50-75 хувийг өөрийнхөө уураг тархийг тэжээхэд хэрэглэдэг².
- Та өөрийнхөө хүүхдийн өсөлт, хөгжлийг ажиглан дараах хүснэгтэнд мэдээллийг оруулж, хүүхдийн эмч, сургуулийн өмнөх боловсролын багш, хүүхдийн мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж болно:

2 НҮБХС, Тархины хөгжил: Бага насны хүүхдийн хөгжлийн шинэ гараа

Нас	Өөртөө туслах	Хөгжих	Чадах	Ярих
4-5 нас				
3-4 нас				
2-3 нас				
18-24 сар				
12-18 сар				
9-12 сар				
6-9 сар				
0-6 сар				

Бага насны хүүхэд улам өсөж дэвжих үндэс нь боловсрол юм. Ази Номхон далайн бүсийн Бага насны хүүхдийн сүлжээнээс хүүхдийн хөгжлийг дараах багц шалгууруудаар үнэлдэг:

- Танин мэдэхүйн
- Нийгэмшихүй-сэтгэлийн хөдөлгөөний хөгжил
- Булчин, хөдөлгөөний хөгжил
- Хэл яриа-бичиг үсгийн бэлтгэл
- Эрүүл мэнд, эрүүл ахуйн, аюулгүй байдал
- Соёл, зан заншлын мэдлэг, оролцоо
- Сурах хандлага

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан, Монгол Улс нэгдэн орж дагаж мөрддөг Хүүхдийн эрхийн тухай Конвенцид хүүхдэд олгох боловсролын зорилгыг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Иймээс таны хүүхэд ямар хүн болж байгааг мэдэхийн тулд энэ дөрвөн чиглэлээр боловсрол эзэмшиж байгаа эсэхийг ямагт нягталж байгаарай.

Хүний эрх, эрх чөлөөг

Эцэг эх, соёл, хэл, үнэт зүйлс, амьдарч байгаа болон төрсөн улс орныхоо үндэсний үнэт зүйлс болон өөрийнхөөсөө ялгаатай соёл иргэншлийг

ХҮНДЭТГЭХ ҮЗЛЭЭР ХҮМҮҮЖҮҮЛЭХ

Байгаль орчныг хайрлан

Харилцан ойлголцол, энхийг эрхэмлэх, хүлцэн тэвчих, эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдал, аливаа ард түмнийг


Та хүсвэл дараах шинж хүүхдэд тань байгаа эсэхийг нягтлаарай:


- **Орчин цагийн нүүдэлчин** – Байгальтай эвсэн амьдарч, орчин цагийн шинжлэх ухааны ололт, дэвшлийг амьдрал, аж ахуйдаа нэвтрүүлэн ашигладаг, нүүдлийн соёлын өвийг тээгч байна.
- **Тэсвэртэй хүй олны гишүүн** – Нийгэм, эдийн засаг, улс төр, байгаль, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийг

давж, эргэн амьдрал ахуйгаа сэргээн босгох чадвартай нийгмийн бүлгийн төлөөлөл байна.

- **Эгэх хариуцлагатай, идэвхтэй иргэн** – Төрийн үйл хэрэгт хуулийн дагуу хүчирхийллийн бус аргаар сайн дураар чөлөөтэй оролцож, өөрийн амьдралд хамаарах шийдвэр гаргахад утга учиртай шууд оролцдог иргэн байна.
- **Хүлцэн тэвчдэг хувь хүн** – Ялгаатай байдлыг ямар нэгэн ташаа бодол, ялгаварлан гадуурхалтгүйгээр хүлээн зөвшөөрч, хүндэтгэж, бусадтай зэрэгцэн амьдарч чаддаг нэгэн байна.

Эцэг эх, гэр бүл нь хүүхдүүдийн сурч боловсрох үндсэн суурь орчинг бүрдүүлдэг. Тиймээс эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ сургуульд сурах бүхий л явцад боловсролын байгууллагын амин чухал бөгөөд зайлшгүй хамтран зүтгэгчид юм. Та багшийг цаг ямагт дэмжиж, түүнтэй байнга харилцаж, хүүхдийнхээ сурлагад 1 дүгээр ангид орсон цагаас хойш 12 дугаар анги төгсөх хүртэл хамтраарай. Гэр бүл, нутгийн олны оролцооны олон хэлбэр нь бүх насны сурагчдын сурлагын амжилтад эерэгээр нөлөөлдөг нь бүх судалгаагаар батлагдсан байна. Танд багшийн дэмжлэг хэрэгтэй, багшид таны туслалцаа чухал шүү.





“ӨНӨӨДӨР СУРГУУЛЬ ДЭЭР ЯМАР БАЙВ?”

ГЭСЭН АСУУЛТЫГ ОРЛОХ 15 АСУУЛТ³

Хүүхдүүдээсээ чухал мэдээлэл авахад тань эдгээр асуулт тусална.

Та хичнээн удаа хүүхдээс “Өнөөдөр сургууль дээр ямар байв?” гэж асуугаад хариу байхгүй таг чиг болоход нь сэтгэлээр унаж байсан бэ? Анхандаа хариу нэг их авахгүй ч энэ асуултыг хүүхдээсээ байнга асуугаарай.

Заримдаа жинхэнээсээ ярилцах чадал байхгүй байх үе эцэг эхэд тохиолдоно. Багш хүний хувьд хүүхдүүд сургууль дээрээ тэдний хийдэг гайхамшигтай зүйлсийг эцэг эхчүүд мэдээсэй гэж их хүсдэг хэдий ч түүнийг хэрхэн яаж гүйцэлдүүлэхээ мэддэггүй юм.


Таны хүүхэд ерөнхий боловсролын сургуульд сурдаг. Ялангуяа бага ангис илүүтэйгээр дунд ангийн сурагчтай бол таны мэдэж байвал зохих зүйл их байдаг. Үүнтэй уялдан хүүхдээсээ мэдээлэл лавлан авах асуултын жагсаалт гаргасан юм.

Асуулт

Үг хэллэгийг нь жаахан өөрчлөхөд эдгээр асуулт бүх насны хүүхдүүдэд тохирно.

3 Елена Агилар, Калифорни мужийн Оклэнд хотын Хувьсан өөрчлөгдөх Удирдлагын хөтөлбөрийн арга зүйч

1. Өнөөдөр сурч байгаа зүйлийнхээ талаар сэтгэл догдлон хөөрсөн үеийнхээ тухай ярь даа.
2. Ангидаа мэгдэж тэвдсэн, самуурсан, будилж сандарсан үеийнхээ тухай ярь даа.
3. Чи өнөөдөр сургууль дээрээ юу сурсан, юу хийсэн тухайгаа бод. Ямар нэгэн илүү мэдмээр юм байна уу? Та нарын өнөөдрийн үзсэн хичээлээс чинь асуух юм гарав уу?
4. Өнөөдөр санааг чинь зовоосон юм болсон уу? Хэзээ аймаар байсан бэ?
5. Чамд хэн нэгэн хүндэтгэлгүй хандсан үе өнөөдөр гарсан уу? Тэр мөчүүдийн тухай надад ярьж өгөөч.
6. Танай ангийн эсвэл хэн нэгэн чамд анхаарал халамж тавьж байна гэдгийг чи мэдрэх үе өнөөдөр тохиолдсон уу?
7. Чи өөрөөрөө бахархмаар мөчүүд өнөөдөр тохиолдсон уу?
8. Ангийнхаа хүүхдүүдтэй эсвэл найз нартайгаа ярьсан, та нарт таалагдсан ярианыхаа тухай надад яриач.
9. Өнөөдрийн хувьд хүнд хэцүү юм юу байсан бэ?
10. Өнөөдөр чамд таалагдсан юм юу байна?
11. Өнөөдөр чи өөрийнхөө талаар шинэ юм мэдэж авсан уу?
12. Би чамд шийдэх эсвэл ойлгоход чинь тусалж чадах ямар нэг юм байна уу?
13. Чиний санааг зовоож байгаа ямар нэг зүйл байна уу?
14. Чи маргааш юу болоосой гэж хүлээж байна?
15. Чиний өнгөрүүлсэн өдрийн талаар намайг асуугаасай гэж бодож байгаа асуулт байна уу?



Асуулт тавихдаа анхаарах санамж

Хэзээ, яаж энэ асуултуудыг асуусан бэ гэдгээс хамааран хүүхдүүдээсээ бидний авах мэдээлэл их ялгаатай байдаг. Нэгдүгээрт, энэ бүх асуултыг нэг өдөр асуухыг та хүсэхгүй. Та эдгээрээс эхний удаа нэг юм уу, хоёрыг нь асууж болно. Та анхаарал төвлөрүүлэх чадвартай байх үедээ, танай хүүхэд таны анхаарлыг бүрэн татаж байна гэдгийг мэдрэхээр үед та асуултуудаа тавиарай. Миний хүүхэд, манай гэр бүлийнхний хувьд оройн хоолны үе эсвэл мотоцикль, машинаар явахдаа энэ яриаг хийхэд хамгийн тохиромжтой үе байдаг.


Одоо энэ асуултууд хэвшил болсон гэж үзвэл... Бид нар сургууль руу мотоцикль, машинаар явж байхад би хүүхдээсээ тэр юу хүсэж байгааг, түүний санааг зовоож байгаа юм байгаа эсэхийг, эсвэл түүнд шийдэх эсвэл ойлгоход нь миний тусалж чадах ямар нэг юм байгаа эсэхийг асууна гэдгийг хүүхдэдээ мэдрүүлээрэй.

Нэмэлт санал

Дараах санаа таны яриаг эерэг бас хүчтэй болгоход тусалж чадна:

- Яриаг нь битгий таслаарай. Энэ бол ямар ч үед ярьж байхад их хэрэгтэй сайн дүрэм, ялангуяа та хүүхдээсээ аль болох их мэдээлэл сонсохыг хүсэж байгаа бол бүр ч хэрэгтэй.
- Илүү ихийг ярих хүсэлт тавиарай. Зүгээр л “Би энэ талаар илүү ихийг сонсохыг хүсэж байна...” гэж эсвэл “Энэ тухай дахиад жаахан дэлгэрүүлээд яриад өгөөч” гэж хэлээрэй.

- Мэдрэмжийнх нь тухай асуугаарай. Болсон юмны талаар хүүхэд ярьж дууссаны дараа “Энэ үед чамд ямар санагдаж байв? Чи өөртөө төрсөн мэдрэмжийн талаар юу анзаарсан бэ?” гэх мэтээр асуугаарай.
- Мэдрэмжийг нь үнэлж дүгнээрэй. Таны хүүхэд юу ч мэдрсэн бай, тэр бол хэвийн юм. Үүнийгээ тэдэнд мэдэгд. Янз бүрийн мэдрэмж төрөх нь хэвийн зүйл. Тэдэнд үүнийг хэлээрэй.
- Багш нар эсвэл хүүхдүүд хатуу хахир эсвэл муу санаатай байх нь сайн зүйл биш гэдгийг тэдэнд хэл. Багш нь хашгичиж загнасан эсвэл тэднийг хүндэтгээгүй (тэд юу хийсэн эсвэл хэлсэн нь хамаагүй) тухай танд яривал насанд хүрэгчид тэдэнтэй тэгж харьцах нь сайн юм биш гэдгийг хэл. Бусад хүүхдүүд бас тийм харьцаа гаргасан бол мөн адил гэж хэлээрэй.
- Санаа бодол, болсон зүйлээ хуваалцсанд нь талархал илэрхийл. Тэдний үнэнч шударга зан, гэгээтэй сайхан явдлууд болон хүндрэл бэрхшээлээ илэн далангүй хуваалцсанд нь талархлаа илэрхийлээрэй.



6 ДАХЬ ӨДӨР ХҮҮХДИЙН ОРОН ЗАЙ



Хүүхэд амьдарч, суралцаж байгаа орчин өөрт нь тохирсон, ээлтэй, таатай байвал хүүхэд улам өсөж дэвжихэд тустай гэж үздэг. Юуны өмнө хүүхдийн орон зайг хангахдаа өөрийн гэсэн булан, өрөө, эд хэрэглэл, номын сан, хувцас, шүүгээ зэргийг бэлдэх нь чухал. Мөн хүүхэд та нартай чөлөөтэй харилцах, санаа бодлоо илэрхийлэх боломжоор хангаарай. Тодруулбал өөрийг нь шоолох, ичээх, эсвэл үгүйсгэх бус, үгийг нь сонсож,

хамтдаа шийдвэр гаргадаг гэсэн ойлголтыг багаас нь өгөхийг зориорой. Үүний тулд та хүүхдийнхээ санааг сонсохдоо бүтэн өгүүлбэрээр, гүйцэд илэрхийлж сургаарай. Та өөрөө бүтэн өгүүлбэрээр ярьж, шууд ойлгомжтой санаагаа илэрхийлж сурах шаардлага ч гарч мэднэ. Өөрөө ч гэсэн бэлтгэлтэй байгаарай.

Хүүхэд насны хамгийн тод дурсамж таны хувьд юу вэ?

- Хамгийн шударга бус санагдсан, одоо хүртэл мартаагүй...
- Хамгийн сайхан, аз жаргалтай санагдсан, одоо хүртэл санаж баярладаг...
- Хамгийн санахыг хүсдэггүй, мартмаар санагддаг...
- Хамгийн баяр хөөртэй, бодмогц инээмсэглэл тодордог...

Эргээд харахад хүүхдэдээ орон зайг гаргаж өгөх нь байнга эргэн санахуйц дурсамжийг төрүүлэх хөрс юм шүү. Цаашилбал өрх гэрээс эхлэн орон нутаг хүртэл хүүхдээ дээдлэн тэдний төлөө бүх зүйлийг хийдэг байх ёстой. Хүүхдэд зориулсан бүхий л зүйлс нь хүүхдийг айлгахуй, баяр хөөртэй, инээмсэглэл тодруулан явахад анхаарна гэсэн үг.


Хүүхдэд ээлтэй өрх⁴	Хүүхдийн эн тэргүүний хэрэгцээг хангах өрх–эцэг эх, гэр бүлийн бусад гишүүд
Хүүхдэд ээлтэй орчин	Гудамж, нийтийн эзэмшлийн талбай, ногоон байгууламж, нийтийн тээвэр, чөлөөт цаг, тоглоомын талбай, театр, спорт цогцолбор
Хүүхдэд ээлтэй үйлчилгээ	Цэцэрлэг, сургууль, эмнэлэг, цагдаа, хүүхдийн төв, дэлгүүр
Хүүхдэд ээлтэй засаглал	Хүүхдийн сайн сайхны төлөөх бодлого, шийдвэр, хөрөнгө оруулалт <ul style="list-style-type: none">• Хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах явцад хүүхдийн оролцоо• Хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн хамтын ажиллагаа

4 НҮБХС, Хүүхдэд ээлтэй хот, орон нутаг санаачилга

Та хүүхдэд ээлтэй орчин мөн эсэхийг дараах түлхүүр б асуулгаар шалгаарай. Өрх гэр, үйлчилгээ, орон нутагт мөн адил үйлчилнэ.

№	Шалгах асуулт	Хариулт	
1	Хүүхэд бүр эрсдлээс ангид, аюулгүй орчин мөн эсэх	Тийм	Үгүй
2	Хүүхэд бүрийг урамшуулсан, дэмжсэн, өсөн дэвжих боломжоор хангасан эсэх	Тийм	Үгүй
3	Тухайн орон нутгийн одоо байгаа бүтэц, чадавхид тулгуурласан эсэх буюу ямар нэгэн төсөл, хөтөлбөрийн дараа ч үргэлжлэх боломжтой эсэх	Тийм	Үгүй
4	Аливаа үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ хүүхдийг бүрэн дүүрэн татан оролцуулдаг эсэх	Тийм	Үгүй
5	Төрийн үйлчилгээ, хөтөлбөрийн дагуу дэмжлэг авч, үр шим хүртдэг эсэх. Жишээлбэл, сургуульд суралцдаг, дотуур байранд амьдардаг, эрүүл мэндийн төвд хүүхдээ урьдчилан сэргийлэх үзлэгт үзүүлдэг, вакцин хийлгэдэг, бүртгэлийн газраас төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх авдаг гэх мэт.	Тийм	Үгүй
6	Хүүхэд бүрийг татан оролцуулсан, ялгаварлан гадуурхдаггүй эсэх	Тийм	Үгүй


Хэрэв та нэг л удаа “Үгүй” гэж хариулвал хаана, хэрхэн илэрч байгааг хүүхэдтэйгээ хамт зураглаарай.



Хүүхэд тань нэг бүтэн өдрийг хэрхэн өнгөрөөж байгааг хамтдаа үнэлж, хүүхдэд таагүй орчныг тодруулж лавлаарай.

Хүүхдийн нэр	Нэг өдрийн хуваарь	Ээлгүй орчин	Ээж аавын тэмдэглэл
А хүүхэд	Өглөө босоод, гар нүүрээ угаагаад, цэцэрлэгтээ явдаг, орой гэртээ ирдэг, ээж аав ах эгчтэй хоол иддэг, жаахан тоглож байгаад унтдаг.	Өдөр унтахын өмнө цэцэрлэгийн хүүхдүүд тоглоом тоглох гэхээр шоолоод байдаг. Машинаар биш, хүүхэлдэйгээр тоглодог гэдэг.	Цэцэрлэгийн багштай уулзах, хүүхдүүдэд дуртай тоглоомоороо тоглож болохыг багшаар хүүхдүүдэд тайлбарлуулах
	Өглөө босно. Гэрээ цэвэрлэнэ. Ус авна. Гэрийн даалгавраа хийнэ. Өдөр хичээлд явна. Орой хааяа ганцаараа харина. Хоолоо иднэ. Тоглож байгаад унтана.	Орой харихдаа жалгын наана гудамжны нохойд хөөгдөж, уруулах гээд байдаг.	Хүүхдээ сургуулиас очиж авах хуваарь гаргах
В хүүхэд	Өглөө сургуульдаа явна, өдөр түлээ хагална, дүүгээ хүргэж өгнө. Үдээс хойш дугуйланд явдаг. Эрт тарвал дүүгээ сургуулиас авна. Гэрт ирээд хоол хийнэ. Гэрийн даалгавраа хийдэг.	Намар, хавар дугуйлан гадаа хичээллэдэг. Өвөл дугуйлан “халаалтгүй” учраас ордоггүй, “Халаалтын мөнгө байхгүй” гэж багш хэлдэг.	Иргэдийн төлөөлөгчдөд хүүхдүүдийн дугуйланг тасралтгүй явуулахын тулд халаалтын зардлыг нэмэх тухай хүсэлт гаргах

Та төлөвлөсөн ажлаа хийгээд үр дүн гарсан бол, тухайлбал төсвийг шийдүүлж чадсан бол бусад эцэг эх, багш, сургуульд мэдэгдээрэй. Дараагийн удаа бүгд хамтарч болно шүү дээ.



7 ДАХЬ ӨДӨР

ХҮҮХЭД БАЙГАА БҮХ ГАЗРЫГ АНХААР



Таны хүүхэд өдрийг хаана, хэнтэй өнгөрөөдөг вэ? Юу хийдэг вэ? Судалгаагаар та хүүхдээ анхааралтай сонсож, 15 минут ярилцахад өөрт тохиолдож байгаа бэрхшээл, зовнилоо уудалдаг гэдгийг тогтоожээ⁵.

Иймээс хүүхэдтэй багаас нь илэн далангүй ярилцаж, санаа бодлыг нь нээлтэй хэлүүлж сургаарай.

Өнөөдөр та хүүхдийнхээ байнга очдог газруудыг хамтдаа зурах эсвэл тэмдэглээрэй. Заавар:

1. Өмнөх өдөр ашигласан нэг өдрийн дэглэмээ ашиглаж болно. Эсвэл хааяа очдог газар байвал хэзээ, ямар үед очдог болохыг лавлаарай.
2. Сургууль, дотуур байр, тоглоомын талбай, интернэт кафе, дугуйлан, секц, давтлага, түүний цагийн хуваарийг харьцуулж хараарай.
3. Өдөр сургууль дээр, дотуур байранд ямар байдгийг ярилцаарай.
4. Таны хүүхэд болон бусад хүүхэд ямар байдаг, нэг нэгнээ дэмждэг эсвэл шоглодог эсэх, дарамт байдаг талаар заавал асуугаарай.
5. Хэрэв сургууль эсвэл дотуур байрандаа, нэг бол гэртээ ирэх замдаа хэцүү байдаг бол юунаас болж байгааг албадахгүй, шахахгүйгээр нягтлаарай.
6. Таны хүүхэд болон бусад хүүхдэд ямар эрсдэл, аюул тулгардаг талаар давхар асуугаарай.

5 Хүүхдээ нээцгээе: Хүүхэдтэйгээ ярилцах 6 арга (www.parenting.com)

Жишээлбэл:

- Намайг манай ангийнхан хичээл дээр асуугдах үеэр “Аялгатай ярьдаг” гэж шоглодог. Багшид асуугдаж дүн авмаар байсан ч гараа өргөж чаддаггүй.
- Цаснаар мотоцикльтэй хүн гуйж явах эсвэл мотоциклиор явах хэцүү байдаг. Томчууд хүргээд өгчих гэж айлгаад байдаг. Жаахан бензин өгчих гэж дарамтлах гээд байдаг.
- Дотуур байрны том хүүхдүүд дандаа өрөөнд орж ирж зоддог. Гэрээс эргэлт ирмэгц шууд хувааж авна гээд байдаг.
- Теннис, биллиард тоглох гэхээр том хүмүүс тэнд архи ууж байгаа харагддаг. Томчуудтай үед огт тоглож чаддаггүй.
- Дугуйландаа яваад ирэхэд их орой болдог. Харанхуй гудмаас хэн гараад ирэх бол гэж айдаг.
- Дотуур байрны жорлон орой ороход их аймаар. Байрнаас бараг 10 метр зайтай, огт гэрэлгүй, харанхуй, огт хүнгүй газар байрладаг гэх мэт.

Ийнхүү хүүхэдтэйгээ ярилцсаны дараа юу хийх боломжтой, ямар тусламж хэрэгтэй байгааг асуугаарай. Сурагчдын аюулгүй байдлыг мэдрэх нь амжилттай хөгжих, суралцахад чухал нөлөөтэй. Та өөрөө, багштай, эсвэл бусадтай хамтран хийж болох зүйлсээ ярилцаарай. Хуваарь гаргаж хүүхдээ хүргэж өгөх, авах, эцэг эхчүүдтэй нийлэн орчноо сайжруулах, эргүүлд гарах, хүүхдийн эрхийн байцаагчтай уулзах, багш, захирлаас зөвлөгөө авах зэргээр хийж болох боломжтой зүйлээ хийнэ шүү.

8 ДАХЬ ӨДӨР

ХҮҮХДИЙН ТАНЬ СУРГУУЛЬ



Сургуулийн орчныг үндсэндээ гурван зүйлээр та шинжиж хараарай⁶:

- Засаглалын: Сургуулийн түвшинд гарч байгаа шийдвэрт оролцох, санаагаа тусгах, түүнийг мөрдөхөд хамтрах боломжтой эсэх
- Сэтгэлзүйн: Хүүхэд ямар нэгэн айдас, дарамтгүй сургуульдаа очих, суралцах, амьдрах боломжтой эсэх
- Материаллаг: Ширээ, сандал, анги танхим, сургалтын хэрэглэгдэхүүн, биеийн тамирын талбай, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эсхийг эн тэргүүнд хараарай.

Орчин	Шалгуур	Нөхцөл
ЗАСАГЛАЛЫН ОРЧИН	Алсын хараа, бодлого журам, өндөр түвшний стандарттай	<p>Сургууль нь:</p> <ul style="list-style-type: none"> • оролцогч талуудын хамтран боловсруулж, баталсан эрхэм зорилго, алсын хараатай ба хүн бүр ойлгож, мэддэг. • сургуулийн хамт олон хамтран боловсруулсан бодлого, дүрэм, журмаа бичгээр гаргаж мөрддөг. • удирдлага нь сургуулийн аливаа шийдвэр, ялангуяа өөрсөдтэй нь холбоотой шийдвэр гаргахдаа талуудын оролцоог хангадаг, дэмждэг. • мэргэжлийн болон ёс зүйн өндөр стандарт тогтоож, хүн бүрийг хүндэтгэдэг • багш, суралцагч, ажилтнуудын гаргасан ахиц дэвшлийг шударгаар үнэлдэг, энэ талаар дүрэм журамтай • хүн бүр тэднээс юуг, ямар байхыг, яагаад хүсэн хүлээж байгааг ойлгодог
	Холбогдох бүх талуудын оролцоо хамтын ажиллагаатай	<p>Хүүхдийн оролцоо, дуу хоолой:</p> <ul style="list-style-type: none"> • хүүхэд бүрийн дуу хоолойг сонсдог ба тэд шийдвэр гаргахад оролцдог • хүүхдийн өөрсдийн үүсгэл санаачилгын байгууллагатай • сургуулийн зөвлөлд төлөөллөө сурагчид өөрсдөө сонгодог • сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааны талаар хүн бүр саналаа хэлдэг сувагтай ба сурагчдын санал тусгагдан хэрэгжинэ гэсэн итгэлтэй <p>Багш, ажилчдын оролцоо, дуу хоолой:</p> <ul style="list-style-type: none"> • сургуулийн аливаа шийдвэрийг, ялангуяа өөрсөдтэй нь холбоотой шийдвэр гаргахад оролцдог, саналаа хэлдэг • өөрсдийн санаачилгаар мэргэжлийн, ёс зүйн, ур чадварын болон хөдөлмөрийн харилцааны зэрэг асуудлаар эвлэлдэн нэгддэг бөгөөд сургуулийн удирдлага хүлээн зөвшөөрч, дэмждэг • удирдлага нь багш нарыг мэргэжлээ дээшлүүлэхийг бүх талаар дэмждэг, боломж олгодог • сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааны талаар саналаа хэлдэг сувагтай ба тэдний санал тусгагдан, хэрэгжинэ гэсэн итгэлтэй.

6 БНБТ! ИНҮЭ, “Сайн сургуулийг бүтээцгээ!” Сургуулийн орчныг сайжруулах хамтарсан багийн үнэлгээний аргачлалаас

		<p>Эцэг, эхчүүдийн оролцоо, дуу хоолой:</p> <ul style="list-style-type: none"> • сургуулийн зүгээс шаардлагатай мэдээллүүдийг тогтмол хүргэдэг • эцэг эхчүүд сургуульд ажилладаг мэргэжлийн хүмүүсээс тусалцаа дэмжлэг авдаг • эцэг эхчүүдэд чиглэсэн арга хэмжээнүүд тогтмол зохиогддог • өөрсдийн үүсгэл санаачилгын байгууллагатай, тогтмол үйл ажиллагаа явуулдаг • сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааны талаар саналаа хэлдэг сувагтай ба тэдний санал тусгагдан хэрэгжинэ гэсэн итгэлтэй <p>Бусад талуудын оролцоо:</p> <ul style="list-style-type: none"> • иргэний нийгмийн байгууллагууд • хувийн хэвшил, олон улсын байгууллагууд • бусад талуудтай нээлттэй, идэвхтэй хамтран ажилладаг
	<p>Сургуулийн бүхий л үйл ажиллагаа ил тод, нээлттэй ба үнэлгээ, хяналт, хариуцлагатай</p>	<p>Сургуулийн удирдлага нь:</p> <ul style="list-style-type: none"> • сургууль яаж ажиллаж байгааг оролцогч талуудад тайлбарлах, батлах чин хүсэлтэй • сургуулийн зөвлөл зохих ёсоор байгуулагдсан, бүхий л талуудтай зөвшилцөн хамтран ажилладаг, үйл ажиллагааны тайланг тогтмол танилцуулдаг • удирдлагын баг нь чадвартай, бие биеэ дэмжиж ажилладаг, харилцааны өндөр соёлтой • багш, ажилтны амжилтыг шударгаар үнэлж, урамшуулдаг, сургалтын чанар ахицыг байнга тооцож ажилладаг • төсвийн ашиглалт, зарцуулалт ил тод, нээлттэй • хариуцлагын тодорхой тогтолцоотой ба энэ талаар мэдээлэл ил тод байдаг • гарсан зөрчил, ирсэн санал шүүмжлэл, хүсэлтийг цаг хугацаанд нь шийдвэрлэх механизмтай ба ийнхүү шийдэхдээ хүний эрх, шударга ёсыг эрхэмлэдэг
<p>СЭТГЭЛ ЗҮЙН ОРЧИН</p>	<p>Эерэг уур амьсгал</p>	<p>Багш, удирдлага, сурагч, ажилчид гээд хүн бүр:</p> <ul style="list-style-type: none"> • бие биеэ хүндэтгэдэг • хүлээн зөвшөөрдөг • урам хайрладаг • амжилтыг нь бодитой үнэлдэг • алдааг нь сургамж болгоход дэмжлэг үзүүлдэг • бие биедээ тусалдаг • бүгд ажилдаа дур сонирхолтой байдаг.




	Бие махбодийн шийтгэл, хүчирхийллээс хамгаалагдсан байх	Багш, ажилтнууд: <ul style="list-style-type: none"> • эерэг хүмүүжлийн арга хэрэглэдэг • суралцагчид асуудал тулгарахад хэнд хандахаа мэддэг • сурагчдын нууцыг хадгалдаг • бие биедээ анхаарал халамж тавьдаг • бие махбодийн шийтгэл, бэлгийн дарамт, хүчирхийллийн аливаа хэлбэрийг хорьсон дүрэм журам баталж хэрэгжүүлдэг.
	Сэтгэл зүйн дарамт, ялгаварлан гадуурхалтгүй	Сургуульд: <ul style="list-style-type: none"> • охид хөвгүүд, эрэгтэй эмэгтэйчүүдийн тэгш эрх хангагдсан, адил боломж олгодог • багш ажилтнууд хүүхдийн сайн сайхны төлөө хамтран ажилладаг, багшийн ёс зүйн дүрмээ мэддэг, ухамсарладаг • маргиналчлагдсан бүлгийн сурагчид, тэдгээрийн эцэг эх бусдын адил эрх, боломжийг эдэлдэг ба тэдний нөхцөл байдлыг байнга анхаарч ажилладаг • сурагч болон бусад бүх талуудын ялгаатай байдлыг ойлгож хүлээн зөвшөөрч, хүндэтгэн үздэг.
	Өөрийгөө хөгжүүлэх боломж	Сургуулийн үйл ажиллагаанд: <ul style="list-style-type: none"> • хүн бүр ямар нэг албадлага, шахалт, өрсөлдөөнгүйгээр өөрсдийн дур сонирхлоор хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцдог • төрөл бүрийн дугуйлан, секц сонгон хичээллэдэг • сурагчид өөрсдөө үйл ажиллагаа санаачлан зохион байгуулахыг дэмждэг • багш, удирдах болон бусад ажилтны өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагааг дэмждэг.
МАТЕРИАЛЛАГ ОРЧИН	Хүрэлцээ, хүртээмжтэй байдал	Сургуулийн орчин: <ul style="list-style-type: none"> • хүүхэд бүр, ялангуяа бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нийцсэн • анги танхим хүрэлцээтэй, гэрэлтүүлэг сайтай, анги дүүргэлт стандартад нийцсэн • халаалт, дулаан сайтай • самбар, ширээ, сандал, мэдээллийн самбар, сургалтанд хэрэглэх хэвлэх, хувилах тоног төхөөрөмж зэрэг хүрэлцээтэй, чанартай хэрэгслүүдтэй • шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон хурлын танхим, урлаг, спортын заал, ажилчдын амрах өрөөтэй



	<ul style="list-style-type: none"> • сурагчид, эцэг эхчүүдийн дунд хичээлээс гадуур үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжтой • гадаа талбай ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлттэй ба сандал, сүүдрэвчтэй • дотуур байр тав тухтай, суралцагчдын эрүүл, аюулгүй байдлыг бүрэн хангасан <p>Хүн бүрийн потенциалыг дээшлүүлэх боломжтой:</p> <ul style="list-style-type: none"> • сурах бичгийн хангамж сайтай (хүүхэд бүр) • номын сантай, уншлагын танхим хүрэлцээтэй • интернэт, компьютер хүрэлцээтэй • хичээлийн кабинетүүдтэй • эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх өрөө, тоног төхөөрөмжтэй • багш хөгжлийн төвтэй ба багшид зориулсан сургалтын материал сургалтын хэрэглэгдэхүүнээр бүрэн хангадаг • дугуйлан хичээллүүлэхэд хэрэгтэй хөгжмийн зэмсэг, спортын төхөөрөмж, хэрэгсэлтэй
Эрүүл, аюулгүй байдал	<p>Ариун цэвэр, халдваргүйжилт:</p> <ul style="list-style-type: none"> • цэвэр, бохир усны асуудлаа шийдсэн (төвлөрсөн системд холбогдсон) • ариун цэврийн өрөө, угаалтуурын хүртээмжтэй, хүйсээр,насаар тусдаа байдаг • ариун цэврийн чанартай материал, хэрэглэгдэхүүнээр хангагддаг • анги танхимын ариун цэвэр сайн • хоол цайны газрын ариун цэвэр, эрүүл ахуйн байдал • хог хаягдлын асуудлаа шийдсэн <p>Аюулгүй байдал:</p> <ul style="list-style-type: none"> • сургуулийн үүдний довжоо, шат халтирдаггүй, хашлага, цонх, хаалга зэрэг нь аюулгүй • сургуулийн эргэн тойрны зам гарц, тэмдэглэгээ, хурд сааруулагчтай • үдийн цай чанартай, тэжээллэг • галын аюулгүй байдал хангасан, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх боломжтой

Хэрэв бүх шинжийг “Тийм”, “Байдаг” гэж хариулсан бол маш сайн буюу таны хүүхдийн сургууль нь сайн сургууль юм байна. Хариулж мэдэхгүй байвал та хүүхдээсээ гадна багш, нийгмийн ажилтан, захирал зэргээс тодруулах зүйлээ асууж болно шүү. Хэрэв аль нэг шинж дутагдаж байвал түүнийг сайжруулахын тулд эцэг эхийн хурал, уулзалтанд оролцож, саналаа хэлэх эсвэл өөрөө сайн дураар ажиллах хүслээ илэрхийлж болно.



9 ДЭХ ӨДӨР

САЙН ДУРААР ГАР БИЕ ОРОЛЦОХ

Эцэг эхчүүдийн хувьд хүүхдэдээ төдийгүй хамт сурч байгаа хүүхдүүдэд анхаарал тавьснаар ангийн сурлагын амжилтыг дээшлүүлнэ шүү. Хэрэв таны хүүхдийг шоолдоггүй эсвэл дээрэлхдэггүй байсан ч гэсэн нэг хүүхдийг шоолдог, дээрэлхдэг нөхөр байгаа эсэхийг заавал асуугаарай. Яагаад вэ гэвэл ийнхүү нэгнээ шоолж, дээрэлхэж байхад дуугарахгүй байна гэдэг нь ирээдүйд бусдын буруу үйлдлийг хэлж чадахгүй нэгэн болох эрсдэлтэй. Харин хэлж бай хэмээн сургавал нийгэмд болохгүй байгаа зүйлийг өөрчлөхийн төлөө зүтгэдэг хүн болно.

Байнга хүүхдүүдээр дээрэлхүүлээд эсвэл шоолуулаад байгаа хүүхдийн сэтгэл санаа тогтворгүй болж, анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байдалд ордог. Аажимдаа хичээлээс хоцорч, сурах идэвхгүй болж, удалгүй сургуулиас хөндийрөхөд хүрдэг гэмтэй. Бүр удвал хүүхэд амиа хорлож ч магадгүй эрсдэлтэй нөхцөл үүсдэг байна.

Дарамт

Стресс

Сэтгэл
гутрал

Ужиг
өвчин

Амиа
хорлолт

Багш олон хүүхэдтэй ажилладаг тул эцэг эхийн зүгээс тулахад бэлэн гэж сонсвол маш их баярладаг. Мөн хамтран хүүхдийнхээ төлөө анхаарч эхэлмэгц хүүхдийн сурлагын

амжилт ч сайжирдаг. Та багштай харилцах дэвтэр нээж, хүүхдийнхээ талаар тэмдэглэн бичиж, мэдэхгүй, асуух зүйлээ лавлаж асуух боломжтой.

Эцэг эхийн хурлын зэрэгцээ сургуулиас зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, өдөрлөг, арга хэмжээнд аль болох оролцоорой. Хүүхдийн цагаан толгойн үсэглэлийн баяр, Шинэ жилээр бүтээсэн дүр, Цагаан сард зориулсан соёлын арга хэмжээ, Анги дэвших шалгалт, Сурагчийн бүтээлийн үзэсгэлэн, Намрын спартакиад, Музей, Аялал, Үзэсгэлэн гэх мэт хичээлээс гадуурх үйл ажиллагаа зэрэг бүх үйл ажиллагаанд оролцож, хүүхэдтэйгээ хамт цагийг өнгөрөөнгөө багшид туслаарай.

Хүүхдийнхээ сургуулийн үйл ажиллагаанд сайн дураар гар бие оролцонгоо хүүхдээ дарамтгүй орчин суралцах боломжийг бүрдүүлээрэй.



10 ДАХЬ ӨДӨР БАГШТАЙ ЯРИЛЦААРАЙ.



Бид эцэг эхийн хувиар багшдаа ярилцахдаа ямар байдлаар харилцдаг вэ?

1. Багшийн аясаар үгийг нь дагуулан байснаа хүүхдээ хурдан авч гаран, яравчлан харьдаг уу?

2. Багшийн хэлсэн үг, тавьсан шаардлагыг сонсохоос тээршааж, “Таны хийх ёстой ажил. Багш бол багшийн ажлаа хий” гэж зандарч гардаг уу?

3. “Би энэ багшийн оронд байсан бол” гэж бодон, өдөржин хүүхдүүдийн өмнө зогсож, олон хүүхдэд хүрэхээр хичээж байгаа хэмээн төсөөлдөг үү?
4. Багшийн санал, шаардлагыг сонсож, өөрт тулгамдаад байгаа асуудлаа чөлөөтэй ярилцан, нэг нэгнээ тусалж дэмждэг үү?

Хүүхдийн сурлагыг сайжруулах, үр чадвартай болгохын тулд ачаалал ихтэй багшид тусламж маш чухал шүү. Үүнийг хэрхэн ярилцах, харилцахаасаа эхлүүлэх хэрэгтэй.

Та өөрийгөө чөлөөтэй илэрхийлж чаддаггүй, тэр бүр бодсон санаснаа шууд хэлэхээс цааргалдаг, бодож байж хариу

хэлдэг бол анхандаа багштай харилцах дэвтэр нээж болно. Түүгээрээ дамжуулаад харилцаж, асуух, лавлах, тодруулах, санал болгох зүйлээ бичих боломжтой.

Хоёр хүн харилцаж байгаа тохиолдолд ярих, сонсох хамт байх ёстой. Та зөвхөн яриад, нэг бол сонсоод л байвал үр дүнтэй яриа болохгүй. Иймээс та ямар нэгэн хариу хэлэхийн төлөө сонсох биш, харилцан ярилцахын төлөө чих тавиарай. Багш ч гэсэн өөрийнхөө үгийг хэлсний дараа таныг хариу хэлэхийг хүлээдэг учир дуугүй байх нь үр дүнтэй аргад тооцогдохгүй. Мөн багш санал хэлж, шаардлага тавихыг сонсохгүй, нэг бол



зөвхөн өнгөрснийг яриад, “Миний хүүхэд сэргэлэн, сурлагатай байснаа муудчихлаа. Танаас л боллоо. Та ажиллахгүй байна” гэх нь өөрөө ухвар мөчид болно.

Та багштай нэг талд зогсож, санаа бодлоороо нэгдэх нь хүүхдийн төлөө

хамтдаа зүтгэх гол тулгуур, эхний алхам шүү. Та гэртээ ч хүүхдийнхээ санаа бодлыг сонсох, гэр бүлийн гишүүдээс

ЯРИХ болон СОНСОХ 4 арга



санал авахдаа хүртэл энэхүү аргыг ашиглаж болно.

Та багштай ярьсан байдлаа эргэн харж, А хавтгайд дүрсэлсэн шиг багшийг зөвхөн сонсоод хариу хэлэлгүй өнгөрсөн, эсвэл "За" гээд гарсан яриа юу, эсвэл Б хавтгайд дүрсэлсэн шиг багштай мэтгэлцэж, дайрч доромжилж, уур бухимдлаа багшид гаргаад өнгөрсөн яриа болсон уу гэдгээ бодож үзээрэй. Та цаашид зөвхөн В, Г хавтгайд дүрсэлсэн байдлаар багштай харилцахыг хичээж дадлагажаарай. Өөрөөр хэлбэл, ирээдүй рүү, цаашид юу хийх, юуг өөрчлөх, ямар болох талаар яриагаа бодож өрнүүлэх нь хэн хэндээ ашигтай.

Эцэг эхчүүд бидний ихэнх нь 20-р зууны үеийн сургуульд сурсан нь бодит үнэн. Одоо бид 21-р зууны сургуулийн өөрчлөгдсөн нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байна. Жишээлбэл:

- Цаашид өгсөн гэрийн даалгаврын хэмжээгээр багшийн чанарыг шүүх боломжгүй.
- Чимээгүй, дуулгавартай хүүхдүүд нь хичээлд оролцож байгаа сурагчдын шинж тэмдэг байх албагүй юм.
- Багшийн агуулгын мэдлэг туршлага нь цаашид сурагчийн боловсролыг хянах, хязгаарлах хүчин зүйл байх ёсгүй.
- Сурагчдын анхаарлыг татахын тулд бидэнд эгнээний зохион байгуулалттай ширээнүүд шаардлагагүй юм.
- Сурах явц бүхэлдээ анги танхимаар хязгаарлагдахгүй гэх мэт.



11 ДЭХ ӨДӨР

ТА ХҮҮХДИЙНХЭЭ ХУВЬД ХЭН БЭ?

Та бага насны хүүхдээрээ гэр бүлээ зуруулах, өсвөр насны хүүхэдтэйгээ цаг гарган ярилцах замаар тухайн хүүхдийнхээ хувьд та хэн бэ гэдгээ лавлаж асуугаарай. Зургийн гол төвд анхаарал хандуулан гоё зурахыг хичээж байгаа болон хайнга байдлаар цаасны зах руу зурж байгаа зургаас та ямар байр суурь эзэлдгээ баримжаалж болно. Таны үгийг сонсохоос илүүтэйгээр гэр бүлийн бусад гишүүний буюу эмээ, өвөөгөө сонсож байвал та хүүхэдтэйгээ хамт цаг өнгөрөөхгүй байгаа ажээ.

Хэрэв цаасны гол төвд байрлуулан гараа гарган зурж байгаа, өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ чөлөөтэй хуваалцаж байвал та сайн аав ээж гэж өөрийгөө үнэлж болно.

Та төрсөн цагаас нь эхлэн хамгийн багадаа 6 жил, зарим нь түүнээс олон жил хүүхэдтэйгээ хамт амьдарч, асарч хамгаалсан билээ. Тэгвэл сургуульд орсон үеэс та өөрийгөө хэрхэн харах вэ, танд ямар шинж байх ёстойг дор харуулав:

- **Хайрт:** Ямар нэгэн хариу, тус нэхэхгүйгээр энхрийлж, дотночилж, хайрладаг хүн, мөн бусдыг хэрхэн хайрлахыг үлгэрлэдэг хүн
- **Халамжлагч:** Сул дорой үед нь өргөж, өмгөөлж, халамжилдаг хүн, бусдад хэрхэн санаа тавихыг үлгэрлэдэг хүн
- **Хамгаалагч:** Аюул осол, гэмтлээс сэргийлэн, бусдын халдлагаас хамгаалдаг хүн, мөн өөрийгөө хэрхэн хамгаалахад сургадаг хүн

- **Зөвлөгч:** Тулгамдсан асуудлаа шийдэж чадахгүй үед зааж зөвлөдөг хүн
- **Туслагч:** Чадахгүй зүйлээ хийх, гүйцэтгэхэд гар бие оролцож тусалдаг хүн
- **Дэмжигч:** Ямар нэгэн зүйл санаачлан хийж гүйцэтгэхэд биеэрээ төдийгүй сэтгэлээрээ дэмждэг хүн
- **Найз:** Харилцан нэг нэгнээ ойлгож, анд нөхөр мэт үздэг хүн

Хайрлах, халамжлах, хамгаалах, зөвлөх, туслах, дэмжих, найзлах үүргээ дутуу биелүүлж байгаа мэт санагдвал "Яагаад?" гэдэг асуултыг өөртөө болон гэрийнхэндээ тавиарай:

- Цаг зав бага;
- Ажил ихтэй;
- Гадуур амжуулах зүйл байна;
- Ядарч харьдаг;
- Аж ахуйдаа анхаарахгүй бол болохгүй;
- Тэр бүр ирж, очих боломжгүй;
- Жаахан байна;
- Үг ойлгохгүй гэсэн үгс үнэхээр шалтгаан мөн эсэхийг дахин эргэцүүлээрэй.

12 ДАХЬ ӨДӨР

БҮТЭЭЛЧЭЭР ХАМТРАХ



Та багш, хүүхэдтэйгээ ярилцаж, харилцаж, хамтарч эхэлсэн бол одоо сургуультайгаа хамтрах талаар ярилцацгаая.

Юуны өмнө та сургууль дээр хэн, юу хийдэг болохыг мэдэж аваарай. Тодруулбал:

- Хэн шийдвэр гаргадаг вэ?
- Ямар дүрэм журам, хэм хэмжээг дагадаг вэ?
- Хэн шийдвэр гаргахад оролцдог вэ?
- Тэд ямар зорилгоор шийдвэр гаргадаг вэ?
- Тэд шийдвэр гаргахдаа хэнийг сонсдог вэ?
- Тэдний мөнгө хаанаас гардаг вэ?

• Тэд хэнд хариуцан тайлагнадаг вэ?

Жишээлбэл сургуулийн тухайд:

- Сургуулийн зөвлөл, захирал
- Монгол Улсын хууль, сургуулийн дүрэм, журмыг баримталдаг
- Сургуулийн зөвлөлд сургуулийн захирал, менежер, багш, эцэг эх, хүүхдийн төлөөлөл байдаг бол захирал шийдвэр гаргахдаа бусад талуудтай тухайлбал хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах бол эцэг эхтэй зөвлөлдөх, ярилцах боломжтой байдаг.
- Сургуулийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх, улам

сайжруулах зорилготой ажилладаг.

- Эцэг эх, хүүхэд, орон нутгийн төлөөлөл, ажилтнуудтай зөвлөлдөж харилцах ёстой.
- Улсын болон орон нутгийн төсөв буюу татвар төлөгчдийн мөнгөнөөс гол төлөв үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг.
- Засаг даргын зэрэгцээ сургуулийн багш, ажилтан, эцэг эх, хүүхдэд ажлаа тайлагнах ёстой.

Сургуулийн үйл ажиллагаанд бүтээлчээр хамтран оролцохдоо:

Хэлэлцэх + Асуудал шийдэх = **Бүтээлч хамтын ажиллагаа**
Итгэлцэх

Хэлэлцэх	
Бие биетэйгээ харилцах	Нэг нэгнээ буруушаахгүй, хүүхдийн төлөө гэсэн нэг зорилгоор эв найртай, хүндэтгэлтэй холбоо тогтоох, ярилцах
Бие биеэ сонсох	“Хэн буруутай вэ?” гэдгийг тогтоохоос илүүтэйгээр “Юу хийвэл дээр вэ?” гэдэг асуултад хариулах байдлаар ярих, сонсох
Бие биедээ хариу өгөх	Хэн, юу хийж байгаа, цаашид юу хийх, ямар зүйлд тусламж хэрэгтэй байгаагаа нэг нэгэндээ хэлж, мэдээлдэг, ярилцдаг байх
Харилцаагаа хадгалах, бэхжүүлэх	Харилцах, сонсохоо хадгалж, хүүхдийн төлөө цаашид хийх зүйлсээ төлөвлөдөг, хамтардаг байх

- **Хэлэлцэх:** Хүн бүр дуугарч, саналаа хэлэх, хэрхэн шийдэхээ тодорхойлох
- **Асуудал шийдэх:** Үр дүнд чиглэж, юу хийхээ нарийвчлан тогтож, тохиролцох
- **Итгэлцэх:** Нэг нэгнээ үгүйсгэхгүй, буруушаахгүйгээр хамтран ажиллах, харилцах

Хүүхдийн амжилттай суралцахад хэрэгтэй шийдвэр гаргуулахын төлөө шаардлагатай тохиолдолд сургуулийн төсвийг ч хөндөн ярилцаж болно шүү. Таны сургуулийн захиргаанаас хүсэх эн тэргүүний зүйлс:

- Бүх гэр бүлтэй хоёр урсгалт харилцаа тогтоох;
- Гэр бүлүүдийн ялгаатай хэрэгцээ шаардлагыг хүндэтгэсэн байдлаар хамтран ажиллах
- Төрөл бүрийн сайн дураар ажиллах боломжуудыг санал болгох;



- Гэртээ суралцах боломжийг нэмэгдүүлэхэд эцэг эхчүүдэд шаардлагатай байгаа мэдээллээр хангах; сургалт явуулах
- Сурагчдын суралцах үйл явцад нөлөөлөх шийдвэрийг эцэг эх, сурган хүмүүжүүлэгчид хамтран гаргах, үүнд сургуулийн сургалтын төлөвлөгөөг боловсруулах зэрэг бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

ТА дараах мэдээллийн хуудастай танилцаад өөрийн оролцоог тодорхойлоорой:

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛСАН ЭЦЭГ ЭХИЙН ОРОЛЦООНЫ БОЛОМЖУУД

“Боловсролыг...Төр, олон нийтийн хяналтанд байлгана.”

Та сургууль дээр эцэг эх, суралцагчдын байгууллага байгуулан ажиллуулж оролцоогоо идэвхжүүлж болно.

Эцэг, эх та Сургуулийн удирдах зөвлөлд гишүүнээр сонгогдож болно. Эсвэл таныг төлөөлсөн гишүүнээр дамжуулан сургуулийг удирдахад оролцоно.

Тэгвэл Сургуулийн зөвлөл ямар шийдвэр гаргадаг вэ?

- Сургууль, цэцэрлэгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам батлах, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
- Сургууль, цэцэрлэгийн дэг журам, дотоод зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох;
- Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;

7 Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтаас

- Сургалтын чанар, хүүхэд төлөвшүүлэх, хамгаалах, хөгжүүлэх ажлын үр дүн, түвшинг сайжруулах талаар сургууль, цэцэрлэгийн удирдлага болон үүсгэн байгуулагчид санал тавих;
- Захирал, эрхлэгчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, дэмжлэг үзүүлэх;
- Сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд санал өгөх,
- Зайлшгүй нөхцөл байдлын улмаас хүүхдээ 6 наснаас нь сургуульд элсүүлэх боломжгүй талаар малчин эцэг, эхийн гаргасан хүсэлтийг үндэслэж шийдвэрлэх;
- Сургууль, цэцэрлэгийн батлагдсан төсөв, сангийн зарцуулалтад хяналт тавих, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй танилцах, мэдээлэх;
- Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааны тайланг гаргаж, хамт олны хуралд тайлагнах.

Эцэг эхийн хувиар та дараах байдлаар сургуулийн үйл ажиллагаанд оролцох эрхтэй:

- Боловсролын сургалтын байгууллага, багшийн үйл ажиллагаатай холбогдсон санал, хүсэлт гаргах;
- Хүүхдийнхээ мэдлэг, чадвар, авьяас, бие, сэтгэцийн талаар сургууль, багшаас гаргасан тодорхойлолттой танилцах
- Хүүхдийнхээ суралцах, төлөвших, авьяасыг хөгжүүлэх

8 Боловсролын тухай хуулийн 46 дугаар зүйлээс

сургалт, үйл ажиллагааны үйл явц, үр дүнтэй танилцах.

- Хүүхдийнхээ суралцах, төлөвших, авьяас, чадварыг хөгжүүлэх асуудлаар боловсролын сургалтын байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж болно.

Сургуулийн захирал ТАНЫГ дараах үйл ажиллагаанд оролцуулах үүрэгтэй:

- Сургууль хөгжүүлэх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад багш, сурагч, эцэг, эх, олон нийтийн оролцоо, түншлэлийг ханган ажиллах
- Сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг сургуулийн зөвлөл, багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоотойгоор төлөвлөх, сургалтын орчныг бэхжүүлэх, төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, мэдээлэх;
- Шийдвэр гаргахад багш нарын зөвлөл, заах аргын нэгдэл, багш, суралцагч, эцэг, эх, олон нийтийн оролцоог хангах, сургуулийн үйл ажиллагаа, сургалтын явц, үр дүнгийн талаар нээлттэй мэдээлэх;
- Хичээлээс гадуурх сургалтын ажлыг дугуйлан, түр сургалт, соёл, урлаг, спортын арга хэмжээ зэрэг хэлбэрээр үлгэрчилсэн хөтөлбөр, хуваарийн дагуу холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, иргэдтэй хамтран зохион байгуулна.

9 Бага, дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлээс



Аймаг, нийслэлийн боловсролын газрын дэргэд тухайн нутаг дэвсгэрт явуулах боловсролын үйл ажиллагааны бодлого, хөгжлийн төлөвлөлтийн асуудлаар зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлд ТА гишүүнээр орж ажиллаж болно.



ӨӨРТӨӨ ӨГӨХ ДААЛГАВАР:

Дараагийн удаа эцэг эхийн хуралд оролцоод таны:

1. Асуух асуулт:

.....

2. Гаргах санал:


.....

3. Гар бие оролцон хийж, бүтээх зүйл:

.....



13 ДАХЬ ӨДӨР ДҮР БҮТЭЭ



Таны бодлоор та ямар аав ээж болохыг хүсдэг вэ? Яагаад? Дор үзүүлэх дөрвөн дүрийг өөрийгөө мэт сэтгэн эргэцүүлээрэй. Аль дүр нь таны хүүхдийг илүү сайн сурах, сайн сургуультай байхад туслах вэ?

Хариулыг бичээрэй.

Таны хүүхэд болон бусад хүүхдэд аль эцэг, эх хамгийн их тус, нэмэртэй вэ? Эцэг эхчүүдийн зүгээс “Идэвхтэй ээж, аав нь уулзана биз” гэсэн хандлагаас болоод ангийн эцэг эхийн хуралд 35 хүнээс 7 хүн ирдэг жишээ бий. Цугласан 7 хүн эн тэргүүнд таны хүүхдэд анхаарах уу, эсвэл өөрийн хүүхдэд анхаарах уу? Тухайн эцэг эхийн хуралд ярьсан зүйлээс та дэмжихгүй зүйл гарвал яах вэ? Та оролцоогүй учир шууд санал бодлоо хэлж чадах уу?

№	Би бол	Яагаад гэвэл
1	Хамгийн идэвхгүй эцэг эх	
2	Хамгийн идэвхтэй эцэг эх	
3	Оролцох сонирхолтой ч завгүй төрийн алба хаагч эцэг эх	
4	Оролцох идэвхгүй ч асар их боломж, нөөцтэй эцэг эх	

Хамгийн идэвхгүй эцэг эх



Өөрийнхөө хүүхдэд анхаарахгүй, өөр зүйлийг чухалчилж анхаарснаар хүүхэд тань өөртөө итгэлгүй, эцэг эхээ тусалж дэмжих, хайрлах ойлголтгүй, мэдрэмжгүй, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал үзээгүй нэгэн болж өсдөг. Аажмаар нийгэмд амьдрахдаа идэвхгүй, бусдыг аялдан дагасан, амьдралаа хэнээс ч хамааралгүй авч явж чадахгүй иргэн болдог онцлогтой. Идэвхтэй эцэг эхээс суралцан, хүүхдийнхээ төлөө өөрийгөө өөрчлөөрэй.

<p>Хамгийн идэвхтэй эцэг эх</p> 	<p>Ээж ааваасаа хүүхэд цаашид хэрхэн амьдрах, бусадтай харилцах, үр дүнд хүрэхийн тулд хэрхэн зүтгэхийг үлгэрлэн суралцдаг. Амьдралдаа анхаарал тавьж, гэр бүлээ халамжилдаг, сайн иргэн болж төлөвшдөг. Та хүүхдэдээ сайн үлгэр дууриал үзүүлэхээ бүү мартаарай.</p>
<p>Оролцох сонирхолтой ч завгүй төрийн алба хаагч эцэг эх</p> 	<p>Эцэг эхийн зүгээс хэзээ зав гаргах, ямар үед оролцох боломжтойгоо багшид мэдэгдэж, байнгын холбоо харилцаатай байж, цахим шуудан зэрэг харилцааны хэрэгслээр мэдээллээ солилцож, та идэвх гарган харилцвал боломж байгаа. Та бусад эцэг эхийг манлайлж, сургуулийн үйл ажиллагаанд өөрийн хувь нэмрээ оруулаарай.</p>
<p>Оролцох идэвхгүй ч асар их боломж, нөөцтэй эцэг эх</p> 	<p>Таны санал болгох боломж, бий болгох нөөц таны хүүхдэд төдийгүй сургуулийн амьдрал, багшийн ажил, бусад хүүхдүүдэд ямар их тус нэмэртэйг дахин эргэцүүлээрэй. Таны оруулсан хувь нэмрийг сургууль, орон нутаг, иргэд үнэлж үзнэ гэдэгт бүү эргэлзээрэй.</p>

“Хэн нэгэн тусална биз” хэмээн бодох зуур хэн ч гараа сунгаагүй, арга мухардсан үе багшид тохиолдож байхыг үгүйсгэх аргагүй. “Амны гарз” гэж бодолгүй, чин сэтгэлээсээ “Багш аа, миний чадах, туслах зүйл байвал хэлээрэй” хэмээн уулзах бүртээ сануулж заншаарай.

Та багштай хамтран эцэг эхчүүдээс хамгийн сайн чаддаг зүйл, хобби, сайн дураар хийж өгч чадах зүйлийн талаар судалгааг авч, нэг хичээлийн жилийн турш сайн дурын ажлын төлөвлөгөө гарган хамтран зохион байгуулаарай.



14 ДЭХ ӨДӨР

ХАМТДАА ТӨЛӨВЛӨЕ

ААВ

ӨДӨР БҮР

Та маргааш “Эцэг эхийн аяны богц”-оо сургуульд аваачиж өгнө. Иймээс аяны богц дахин ирэх хүртэл 7 хоног бүр юу хийхээ хүүхэдтэйгээ, гэр бүлийнхэнтэйгээ хамтдаа төлөвлөөрэй.

Жишээ болгож, аавын төлөвлөгөөний загвар хавсаргалаа.

- Хүүхдүүдтэй хамт биеийн тамирын дасгал хийнэ.
- А хүүхдээ өглөө 7:45 цагт цэцэрлэгт хүргэж өгнө.
- Б хүүхдээ өглөө 8 цагт сургуульд хүргэж өгнө.
- В хүүхдээ орой 17:30 цагт сургуулиас авна.
- Хүүхдийнхээ багш бүртэй уулзаж, хэр суралцаж байгаа, ямар туслалцаа хэрэгтэй байгааг тодруулна.
- Даалгавар хийхэд тус бүр 1 цаг тусална.
- Хүүхдүүдийн сонголтоор 30 мин үлгэрийн эсвэл уран зохиолын ном уншина.
- Хүүхдүүдтэйгээ хамт 21:00 цагт гар нүүр, шүдээ угааж, орондоо орно.
 - Бүх ТВ, радио, интернэт, утсаа унтрааж, өглөө босох хүмүүс сэрүүлгээ тавина.



ДАВАА

- Өглөөний цай бэлтгэж, хүүхдүүдэд уулгана.
- Өдөр хичээлдээ явах хүүхдэдээ цай бэлдэж үлдээнэ.
- Шинэ түүх ярьж өгнө.

МЯГМАР

- Сургалтын материал хийхэд багшид тусална.
- Теннис тоглоно.
- Хүүхдүүдийг усанд оруулна.
- Өдрийн тэмдэглэл хөтөлнө.

ЛХАГВА

- Өглөөний цай бэлтгэж, хүүхдүүдэд уулгана.
- Өдөр хичээлдээ явах хүүхдэдээ цай бэлдэж үлдээнэ.
- Номын сангаас авсан шинэ ном уншиж өгнө.

ПҮРЭВ

- Эцэг эхийн хуралд сууна.
- Биеийн тамирын зааланд тоглоно.
- Хүүхдүүдийг усанд оруулна.

БААСАН

- Өглөөний цай бэлтгэж, хүүхдүүдэд уулгана.
- Өдөр хичээлдээ явах хүүхдэдээ цай бэлдэж үлдээнэ.
- Дугуй унана.

БЯМБА

- Номын сан орно.
- Эмээ өвөөгийн дөө эсвэл нагацын айлд зочилно.
- Хамтдаа ямар нэг зүйл урлан хийнэ.

НЯМ

- Орой гэр бүлийн хурал хийнэ.
- Өөрийн идэх дуртай хоолоо хүүхдүүдтэйгээ хамт бэлтгэж, оройн хоол хийнэ.
- Хүүхдүүдийг усанд оруулна.

Үүнийг нэг бүрчлэн биелүүлэхээ бүгд харилцан тохиролцож, нэг нэгэндээ амлаарай. Өөрсдийнхөө гарын эсвэл хурууны хээгээр тэмдэг дарж болох юм. Аавын эсвэл ээжийн гарын хээг тойруулан зурж, нэг өдөр хийх ажлыг бичиж болно.

- Та энэхүү даалгаврыг гүйцэтгэхдээ богцон дотор байгаа “Сурагчийн аюулгүй байдал” номыг ашиглан, нэг бүлгийг хоёр өдөрт хуваан, хүүхдэдээ таниулаарай. Тус гарын авлага дахь зөвлөмж, зааврыг гэр бүлтэйгээ хуваалцаж, хамтран нууц үг, дохио, гэр бүлийн гишүүд л мэдэх яриагаа тохирч аваарай.



ТАНД ӨГӨХ УРАМШУУЛАЛ

Та манай богцонд байгаа мэдээллүүдийг сонирхон, дэлгэрүүлж судалмаар байвал дараах вебсайт, аппликейшн рүү орж үзээрэй:

- ✓ Сургуулийн эцэг эх, багшийн холбоо ажиллаж байгаа туршлагыг www.sainsurguuli.mn эсвэл www.facebook.com/sainsurguuli цахим хуудаснаас дэлгэрүүлж үзнэ үү.
- ✓ Хүүхдийн хүмүүжил төлөвшил, хөгжил болон хүүхдийн эрх, хамгааллын талаарх мэдээллийг “ХҮҮХЭД БҮРТ” аппликейшн болон вэбсайтаас авна уу. www.huuhed-burt.mn
- ✓ “ХҮЧИРХЭГ ОХИД-ХҮЧИРХЭГ УЛС” гар утасны аппликейшнийг ашиглаж хүүхдүүддээ бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэгийг олгоорой: “Хүчирхэг Охид-Хүчирхэг Улс” апп нь хүүхэд, өсвөр үе болон залуу эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй бүхий л төрлийн бэлгийн халдлага, дарамт, хүчирхийллийг таних, түүнээс урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголт өгөх зорилготой.
- ✓ Боловсролын орчинд Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох зорилготой “Аюулгүй сургууль” аргачлалыг сонирхоно уу. <https://www.facebook.com/MONFEMNET/>
- ✓ “Цахим орчинд анхаарах зүйлс” Эцэг эхчүүдэд зориулсан гарын авлагатай танилцана уу: <http://uni.cf/2ecUVQP>
- ✓ www.yolo.mn нь өсвөр насныхан болон залууст зориулагдсан сайт бөгөөд тэднийг нийгэмд зөв хүн болж төлөвшихөд нь туслах зорилготой юм. Хамгийн сүүлийн үеийн энтертаймент болон бусад мэдээ мэдээлэл, зөвлөгөө, ярилцлага гээд олон агуулгыг багтаасан.
- ✓ www.ekids.mn цахим хуудсаас хүүхдийн аюулгүй байдлыг цахим орчинд хангах тухай мэдээлэл үзээрэй.
- ✓ Таны болон залуучуудын иргэний болон улс төрийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх, нийгмийн амьдралд идэвхтэй ухамсартай оролцоход туслах, мэдлэг мэдээллийг бүтээлч, хялбар аргаар хүргэх зорилготой гар утасны eYouth MN аппликейшнийг татаж аваарай.





UIH.MN
СУДАЛГААНЫ САН